



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

2024 оны 01 дүгээр сарын 08
№02 (1298)

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠯᠠᠭ
ᠠᠯᠪᠠᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ



ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

06.	Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай	43
07.	Монгол Улсын автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	70
08.	Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	72
09.	Автотээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	74
10.	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай	80
11.	Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай	82
12.	Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	83
13.	Нийслэл хотын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	88
14.	Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	89
15.	Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай	92
16.	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	94

17.	Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	97
18.	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	99
19.	Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	100
20.	Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	103
21.	Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	105
22.	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай	106
23.	Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай	108
24.	Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай	110
25.	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай	112
26.	Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	114
27.	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай	118
28.	Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	120
29.	Барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	143
30.	Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	144
31.	Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	153

32.	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай		159
33.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт оруулах тухай		161
34.	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай		162

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

35.	Хуулийн төсөл буцаах тухай	Дугаар 105	166
36.	Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай	Дугаар 107	168
37.	Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай	Дугаар 108	172
38.	Хянан шалгах түр хорооны ажиллах хугацааг сунгах тухай	Дугаар 115	174

᠒᠘᠐.	ᠰᠡᠭᠡᠨ ᠰᠡᠩᠭᠡᠨ ᠳᠡᠨᠦ᠋ᠨ ᠬᠡᠰᠡᠨᠠᠳᠠᠭ	᠒᠒᠗
᠒᠘᠑.	ᠰᠡᠭᠡᠨ ᠰᠡᠩᠭᠡᠨ ᠳᠡᠨᠦ᠋ᠨ ᠬᠡᠰᠡᠨᠠᠳᠠᠭ	᠒᠒᠘
᠒᠘᠒.	ᠰᠡᠭᠡᠨ ᠰᠡᠩᠭᠡᠨ ᠳᠡᠨᠦ᠋ᠨ ᠬᠡᠰᠡᠨᠠᠳᠠᠭ	᠒᠒᠙
᠒᠘᠓.	ᠰᠡᠭᠡᠨ ᠰᠡᠩᠭᠡᠨ ᠳᠡᠨᠦ᠋ᠨ ᠬᠡᠰᠡᠨᠠᠳᠠᠭ	᠒᠃᠐
᠒᠘᠔.	ᠰᠡᠭᠡᠨ ᠰᠡᠩᠭᠡᠨ ᠳᠡᠨᠦ᠋ᠨ ᠬᠡᠰᠡᠨᠠᠳᠠᠭ	᠒᠃᠑
᠒᠘᠕.	ᠰᠡᠭᠡᠨ ᠰᠡᠩᠭᠡᠨ ᠳᠡᠨᠦ᠋ᠨ ᠬᠡᠰᠡᠨᠠᠳᠠᠭ	᠒᠃᠒

Индигэ Фоло оа Ykka Hor & oa Docelag

᠒᠓᠐.	ᠰᠡᠭᠡᠨ ᠰᠡᠩᠭᠡᠨ ᠳᠡᠨᠦ᠋ᠨ ᠬᠡᠰᠡᠨᠠᠳᠠᠭ	᠒᠒᠗
᠒᠓᠑.	ᠰᠡᠭᠡᠨ ᠰᠡᠩᠭᠡᠨ ᠳᠡᠨᠦ᠋ᠨ ᠬᠡᠰᠡᠨᠠᠳᠠᠭ	᠒᠒᠘
᠒᠓᠒.	ᠰᠡᠭᠡᠨ ᠰᠡᠩᠭᠡᠨ ᠳᠡᠨᠦ᠋ᠨ ᠬᠡᠰᠡᠨᠠᠳᠠᠭ	᠒᠒᠙
᠒᠓᠓.	ᠰᠡᠭᠡᠨ ᠰᠡᠩᠭᠡᠨ ᠳᠡᠨᠦ᠋ᠨ ᠬᠡᠰᠡᠨᠠᠳᠠᠭ	᠒᠃᠐
᠒᠓᠔.	ᠰᠡᠭᠡᠨ ᠰᠡᠩᠭᠡᠨ ᠳᠡᠨᠦ᠋ᠨ ᠬᠡᠰᠡᠨᠠᠳᠠᠭ	᠒᠃᠑
᠒᠓᠕.	ᠰᠡᠭᠡᠨ ᠰᠡᠩᠭᠡᠨ ᠳᠡᠨᠦ᠋ᠨ ᠬᠡᠰᠡᠨᠠᠳᠠᠭ	᠒᠃᠒

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 12 дугаар
сарын 07-ны өдөр

Улаанбаатар
хот

НИЙСЛЭЛ УЛААНБААТАР ХОТЫН ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ ТҮГЖРЭЛИЙГ БУУРУУЛАХ, ГЭР ХОРООЛЛЫГ ОРОН СУУЦЖУУЛАХ ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь иргэний саадгүй зорчих нөхцөлийг нэмэгдүүлэх, нийтийн тээврийн төрөл, хүртээмж, авто зогсоолын ашиглалтыг сайжруулах, хотын төвлөрлийг сааруулж, гэр хорооллыг орон сууцжуулах, түгжрэл, орчны бохирдлоос үүсэх нийгэм, эдийн засгийн нөлөөллийг бууруулахад оршино.

2 дугаар зүйл.Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах хууль тогтоомж

2.1.Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль¹, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль², Автотээврийн тухай хууль³, Авто замын тухай хууль⁴, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль⁵, Газрын тухай хууль⁶, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

¹ Монгол Улсын Үндсэн хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.
² Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2021 оны 35 дугаарт нийтлэгдсэн.
³ Автотээврийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1999 оны 28 дугаарт нийтлэгдсэн.
⁴ Авто замын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2017 оны 22 дугаарт нийтлэгдсэн.
⁵ Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2015 оны 28 дугаарт нийтлэгдсэн.
⁶ Газрын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2002 оны 27 дугаарт нийтлэгдсэн.

3.1.Энэ хууль Монгол Улсын нийслэл Улаанбаатар хот /цаашид “нийслэл хот” гэх/-ын нутаг дэвсгэрт үйлчилнэ.

3.2.Нийслэл хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулахтай холбогдсон энэ хуулиар зохицуулснаас бусад харилцааг холбогдох хуулиар зохицуулна.

4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“авто зогсоол” гэж тээврийн хэрэгслийг байрлуулах, хадгалах зориулалт бүхий талбай, байгууламжийг;

4.1.2.“замын хөдөлгөөний түгжрэл” гэж замын хөдөлгөөний эрчим буурч, авто замаар зорчих тээврийн хэрэгслийн хөдөлгөөний дундаж хурд 20 км/цагт хүрэхгүй, тээврийн хэрэгслийн дараалал нэмэгдэх байнгын шинжтэй үзэгдлийг;

4.1.3.“гэр хорооллыг орон сууцжуулах” гэж нийгмийн зайлшгүй хэрэгцээнд үндэслэн газар чөлөөлөлт хийгдсэн талбайд гэр хорооллыг барилгажуулах үйл ажиллагааг;

4.1.4.“гэр хорооллыг орон сууцжуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэгч” гэж гэр хорооллыг орон сууцжуулах нийслэлийн өмчит хуулийн этгээдийг;

4.1.5.“нийгмийн зайлшгүй хэрэгцээ” гэж нийтийн эрх ашиг, иргэний эрүүл, аюулгүй орчинд амьдрах суурь хэрэгцээг хангах зориулалттай нийтээр ашиглах нийгмийн суурь үйлчилгээний барилга байгууламж, тэдгээрийн шугам, сүлжээ, инженерийн дэд бүтцийг;

4.1.6.“автотээврийн хэрэгсэл” гэж Автотээврийн тухай хуулийн 3.1.1-д заасныг.

ХОЁРДУГААР БҮЛЭГ НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН ТЭЭВЭР, АВТО ЗОГСООЛ

5 дугаар зүйл.Нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэх

5.1.Нийслэл хот олон төрөлт, багтаамж ихтэй нийтийн тээвэр, түүнийг дэмжсэн дэд бүтэцтэй байна.

5.2. Нийслэлийн нийтийн тээврийг төрөлжүүлэн хөгжүүлэхэд холбогдох хууль тогтоомжийн дагуу төрөөс дэмжлэг үзүүлнэ.

5.3. Нийслэл хотын ерөнхий болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, зорчигч урсгалын эрэлт хэрэгцээ, тухайн зорчих хэсгийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөний эрчим, дэд бүтцийг харгалзан тогтвортой зорчилт хөдөлгөөний болон нийтийн тээврийг хөгжүүлэх урт, дунд хугацааны төлөвлөлттэй байна.

5.4. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд⁷ заасны дагуу нийтийн тээврийн үйлчилгээг төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ байгуулах замаар хэрэгжүүлж болно.

5.5. Нийслэл хот нь нийтийн тээврийг хөгжүүлэх сантай байна.

Тайлбар: Энэ хуульд заасан нийслэлийн нийтийн тээвэр гэдэгт Автотээврийн тухай хуулийн 3.1.11-д зааснаас гадна дүүжин тээвэр болон багтаамж ихтэй зорчигч тээврийн үйл ажиллагааг ойлгоно.

6 дугаар зүйл. Такси үйлчилгээний хяналт, зохицуулалт

6.1. Зөвшөөрлийн тухай хуулийн⁸ 8.1 дүгээр зүйлийн 5.12-т заасны дагуу хуулийн этгээд такси үйлчилгээ эрхэлж болно.

6.2. Такси үйлчилгээ эрхлэхэд Автотээврийн тухай хуулийн 15.9, 15.10-т заасан нөхцөл, шаардлагыг хангасан байна.

6.3. Такси үйлчилгээг зорчигч тээвэрлэх дүрэм болон холбогдох стандарт, аюулгүй байдлын шаардлагыг хангасан тээвэрлэгчээр гүйцэтгүүлнэ.

6.4. Нийслэлийн тээврийн асуудал хариуцсан байгууллага такси үйлчилгээнд хяналт тавина.

7 дугаар зүйл. Нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэх сан

7.1. Нийслэл хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, нийтийн тээврийн үйлчилгээний төрөл, чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилго бүхий нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэх сангийн хөрөнгийг дараах арга хэмжээнд зарцуулна:

7.1.1. нийслэлийн нийтийн тээвэрт ашиглах автобусны чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх;

⁷ Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2023 оны 12 дугаарт нийтлэгдсэн.

⁸ Зөвшөөрлийн тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2022 оны 38 дугаарт нийтлэгдсэн.



7.1.2. шинэ төрлийн багтаамж ихтэй нийтийн тээврийн үйлчилгээг нэвтрүүлэх, хөгжүүлэх;

7.1.3. нийтийн тээврийн хэрэгслийн эгнээ, автобусны буудал, авто зогсоолыг төлөвлөх, байгуулах, хөдөлгөөн зохион байгуулах техник, хэрэгсэл, зураг, дуу-дүрсний бичлэгийн болон хэмжилт-хяналтын төхөөрөмж суурилуулах, тоноглох;

7.1.4. нийтийн тээврийн хэрэгсэлд зориулсан авто зогсоол /автопарк/ барих;

7.1.5. нийтийн тээврийн үйлчилгээг хөгжүүлэх, нийслэл хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах чиглэлийн эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг санхүүжүүлэх;

7.1.6. нийтийн тээврийн үйлчилгээг төлөвлөх, зохион байгуулах чиглэлээр ажиллах хүний нөөцийг сургаж, дадлагажуулах.

7.2. Нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, захиран зарцуулах, хяналт тавих журмыг нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал баталж, түүний хэрэгжилтэд хяналт тавина.

7.3. Нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэх сангийн дүрмийг нийслэлийн Засаг дарга батална.

7.4. Нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэх сангийн тайлан, зарцуулалт ил тод, нээлттэй байна.

7.5. Нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэх сан дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

7.5.1. нийтийн тээврийн хэрэгслийг төлбөртэй ашиглуулсны орлого;

7.5.2. Автотээврийн тухай хуулийн 17¹.5-д заасан хязгаарт багтаан шинээр олгох автотээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаар худалдан борлуулсны орлого;

7.5.3. нийтийн тээврийн хэрэгслийн авто зогсоол дахь барилга байгууламжийг хүн, хуулийн этгээдэд төлбөртэй ашиглуулсны орлого;

7.5.4. нийтийн тээврийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл, бүртгэлийн орлого;



7.5.5.нийтийн тээврийг хөгжүүлэхэд чиглэсэн хуулиар хориглоогүй хандив, тусламж, бусад.

8 дугаар зүйл.Авто зогсоол

8.1.Нийслэлийн нутаг дэвсгэрт өмчийн хэлбэрээс үл хамааран авто зогсоолын төрөл, тэдгээрт тавих нийтлэг шаардлагыг хотын стандартаар тогтооно.

8.2.Нийслэлийн нутаг дэвсгэрт нийтийн хэрэгцээний авто зогсоолыг төлөвлөх, барьж байгуулах журмыг нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална.

8.3.Нийслэлийн нутаг дэвсгэрт нийтийн хэрэгцээний авто зогсоолын үйл ажиллагаа эрхлэх журмыг нийслэлийн Засаг дарга батална.

8.4.Нийслэлийн нутаг дэвсгэрт өмчийн хэлбэрээс үл хамааран нийтийн хэрэгцээний зориулалттай авто зогсоолын үйл ажиллагаа эрхлэгч нь авто зогсоолын нэгдсэн системд холбогдсон байна.

8.5.Нийслэлийн өмчлөлийн авто зогсоолын менежмент, авто зогсоолын нэгдсэн системийг нийслэлийн Засаг дарга хариуцна.

9 дүгээр зүйл.Нийслэл хотод олгох тээврийн хэрэгслийн бүртгэл, дугаарын хязгаар

9.1.Нийслэлийн тээврийн хэрэгслийн өсөлт, авто замын сүлжээний нягтрал, замын хөдөлгөөний түгжрэлийг харгалзан нийслэл хотод олгох тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарт хязгаарлалт тогтооно.

9.2.Автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас эрх олгосны дагуу нийслэлийн тээврийн асуудал хариуцсан байгууллага Автотээврийн тухай хуулийн 6.1.11-д заасан тээврийн хэрэгслийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангаар дамжуулан тээврийн хэрэгслийн бүртгэлийг хөтөлнө.

ГУРАВДУГААР БҮЛЭГ НИЙГМИЙН ЗАЙЛШГҮЙ ХЭРЭГЦЭЭГ ҮНДЭСЛЭН ГАЗАР ЧӨЛӨӨЛӨХ, ГЭР ХОРООЛЛЫГ ОРОН СУУЦЖУУЛЖ, БАРИЛГАЖУУЛАХ

10 дугаар зүйл.Нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн газар чөлөөлөх

10.1.Нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд төвлөрлийг сааруулах зорилгоор хотын хөгжлийн ерөнхий болон хэсэгчилсэн ерөнхий



төлөвлөгөө, Засгийн газрын шийдвэрийн дагуу улс, орон нутгийн төсвийн хөрөнгө, төр, хувийн хэвшлийн түншлэл, гадаад улсын зээл, тусламжийн хөрөнгөөр хийгдэх төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхэд нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн энэ хуулийн 10.7-д заасан журмын дагуу газар чөлөөлнө.

10.2.Нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн газрыг дараах зориулалтаар чөлөөлнө:

- 10.2.1.боловсролын үйлчилгээ;
- 10.2.2.эрүүл мэндийн үйлчилгээ;
- 10.2.3.нийгмийн халамжийн үйлчилгээ;
- 10.2.4.нийтийн номын сан, соёлын байгууллага;
- 10.2.5.спортын байгууламж;
- 10.2.6.эрчим хүч;
- 10.2.7.дулаан хангамж;
- 10.2.8.ус хангамж, ариутгах татуурга, цэвэрлэх байгууламж;
- 10.2.9.харилцаа холбооны шугам, сүлжээ;
- 10.2.10.авто болон төмөр зам, гүүр, нүхэн гарц, гарам;
- 10.2.11.гамшгаас хамгаалах үйл ажиллагаа;
- 10.2.12.гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хангах үйл ажиллагаа;
- 10.2.13.хог хаягдлыг зохистой хаях, хадгалах, устгах;
- 10.2.14.тохижилт, цэцэрлэгжүүлэлт;
- 10.2.15.явган зам, дугуйн зам;
- 10.2.16.нийтийн хэрэгцээний авто зогсоол;
- 10.2.17.нийтийн тээвэр, дүүжин тээвэр;
- 10.2.18.гэр хорооллыг орон сууцжуулах.

10.3.Газар албадан чөлөөлөх шийдвэрийг гаргахад тухайн төсөл, арга хэмжээний нөлөөлөлд өртөж байгаа газар өмчлөгч, газар эзэмшигч эрхтэй этгээд, улсын бүртгэлд бүртгэлтэй үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгч иргэн, хуулийн этгээдийн 70-аас доошгүй хувийн дэмжлэгийг авсан байна.

10.4.Энэ хуулийн 10.3-т заасан дэмжлэгийг авсан тохиолдолд бусад өмчлөгч, эзэмшигчийн газрыг энэ хуулийн 10.7-д заасан журмын дагуу нөхөх олговрыг олгох болон газар албадан чөлөөлөх шийдвэрийг нийслэлийн Засаг дарга гаргана.

10.5.Нийслэлийн Засаг дарга газар чөлөөлөлтийн нөлөөлөлд өртсөн иргэн, хуулийн этгээдэд энэ хуулийн 10.4-т заасан шийдвэрийг хүргүүлнэ.

10.6.Газар чөлөөлөлтийн нөлөөлөлд өртсөн иргэнийг ажлын байраар хангах, мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтад хамруулах ажлыг зохион байгуулж болно.

10.7.Нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн газар чөлөөлөх журмыг Засгийн газар батална.

10.8.Нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн газар чөлөөлөх журамд газар чөлөөлөх үйл ажиллагаа, газар чөлөөлөлтийн санхүүжилт, нөлөөлөлд өртөж байгаа иргэн, хуулийн этгээдтэй байгуулах гэрээний загвар, газрын өмчлөх, эзэмших эрх болон үл хөдлөх эд хөрөнгийн эрхийг шилжүүлэх, дуусгавар болгох, төрийн байгууллагын оролцоо, түүний эрх, үүрэг, маргааныг шийдвэрлэх зэрэг асуудлыг тусгана.

11 дүгээр зүйл.Газар чөлөөлөхөд баримтлах зарчим, нөхөх олговрын хэлбэр

11.1.Нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн газар чөлөөлөхөд дараах зарчмыг баримтална:

11.1.1.газар чөлөөлөлтийн үйл ажиллагаа ил тод байх;

11.1.2.иргэн, хуулийн этгээдийн хуулиар хамгаалагдсан мэдээллийг задруулахгүй байх;

11.1.3.чөлөөлсөн газрыг нийгмийн зайлшгүй хэрэгцээнд ашиглах;

11.1.4.чөлөөлөгдсөн газрыг байгальд ээлтэй, нийгмийн суурь хэрэгцээг хангах зориулалтаар төлөвлөж, зохион байгуулах.

11.2.Нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн газар чөлөөлөхөд нөхөх олговрын дараах хэлбэрийн аль нэгийг ашиглана:

11.2.1.газрыг газраар дүйцүүлэн олгох;

11.2.2.газрыг үл хөдлөх болон хөдлөх эд хөрөнгөөр дүйцүүлэн олгох;

11.2.3.газрыг нөхөх олговрын мөнгөн хэлбэрээр худалдан авах;

11.2.4.боломжит бусад.

11.3.Энэ хуулийн 11.2-т заасан хэлбэрүүдийг хослуулан нөхөх олговрыг олгож болох бөгөөд энэ хуулийн 11.2.4-т заасан нөхөх олговрын бусад боломжит хэлбэрийг энэ хуулийн 10.7-д заасан журамд тусгана.

12 дугаар зүйл.Газрын нөхөх олговрын үнэлгээ

12.1.Газар чөлөөлөлтийн нөлөөлөлд өртөж байгаа иргэн, хуулийн этгээдийн газар, үл хөдлөх эд хөрөнгийн үнэлгээг эрх бүхий этгээд Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн⁹ 7.2.4-т заасан газар, үл хөдлөх эд хөрөнгийн нөхөх олговрын зориулалттай үнэлгээний аргачлалын дагуу үнэлгээ хийх тусгай зөвшөөрөлтэй этгээдээр хийлгэнэ.

12.2.Газар чөлөөлөлтийн нөлөөлөлд өртөж байгаа иргэн, хуулийн этгээд энэ хуулийн 12.1-д заасан үнэлгээг эс зөвшөөрвөл уг үнэлгээтэй танилцсан өдрөөс хойш 14 хоногийн дотор өөрийн зардлаар үнэлгээ хийх тусгай зөвшөөрөлтэй этгээдээр хийлгэж болно.

12.3.Газар чөлөөлөлтийн нөлөөлөлд өртөж байгаа иргэн, хуулийн этгээд хүндэтгэн үзэх шалтгааны улмаас энэ хуулийн 12.2-т заасан хугацаанд үнэлгээ хийлгээгүй бол уг хугацаа дууссанаас хойш 14 хоног багтаан үнэлгээг хийлгэнэ.

12.4.Энэ хуулийн 12.1, 12.2-т заасан үнэлгээ зөрүүтэй байвал Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 22.1-д заасан хөрөнгийн үнэлгээний мэргэжлийн байгууллагад хандаж шийдвэрлүүлнэ.

12.5.Газар чөлөөлөлтийн нөлөөлөлд өртөж байгаа иргэн, хуулийн этгээд энэ хуулийн 12.2-т заасан хугацаанд үнэлгээ хийлгээгүй бол энэ хуулийн 12.1-д заасан үнэлгээг хүлээн зөвшөөрсөнд тооцно.

13 дугаар зүйл.Гэр хорооллыг орон сууцжуулах байршил

13.1.Нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хотын хөгжлийн ерөнхий болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан дэд төвийн байршилд гэр хорооллыг тэргүүн ээлжинд орон сууцжуулна.

13.2.Энэ хуулийн 13.1-д заасны дагуу орон сууцжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ нийгмийн суурь үйлчилгээ болох соёл, боловсрол, эрүүл мэнд, нийтийн үйлчилгээг цогц байдлаар төлөвлөж хэрэгжүүлнэ.

Тайлбар: Энэ хуульд заасан “дэд төв” гэдэгт нийгмийн зайлшгүй хэрэгцээнд үндэслэн хотын хөгжлийн ерөнхий болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан байршилд гэр хорооллыг орон сууцжуулж, барилгажуулахаар төлөвлөсөн нийгмийн суурь үйлчилгээний барилга байгууламж, тэдгээрийн шугам, сүлжээ, инженерийн дэд бүтцийн цогцолборыг ойлгоно.

⁹ Хөрөнгийн үнэлгээний тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2022 оны 37 дугаарт нийтлэгдсэн.



14 дүгээр зүйл. Гэр хорооллыг орон сууцжуулахад төрөөс үзүүлэх дэмжлэг, санхүүжилт

14.1. Нийслэлийн гэр хорооллыг орон сууцжуулж, барилгажуулахад холбогдох хууль тогтоомжийн дагуу төрөөс дэмжлэг үзүүлнэ.

14.2. Нийслэлийн гэр хорооллыг орон сууцжуулах үйл ажиллагааг Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн¹⁰ 21 дүгээр зүйлд заасан хөрөнгийн эх үүсвэрээр санхүүжүүлнэ.

15 дугаар зүйл. Гэр хорооллыг орон сууцжуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэгчийн чиг үүрэг

15.1. Гэр хорооллыг орон сууцжуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэгч дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

15.1.1. хот байгуулалтын холбогдох баримт бичгийг эрх бүхий байгууллагаар батлуулах;

15.1.2. төсөл хэрэгжүүлэгчийг нээлттэй сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, төслийг нэгдсэн удирдлагаар хангах, хэрэгжилтэд хяналт тавих;

15.1.3. дэд төвөөс олгогдох инженерийн шугам сүлжээний техникийн нөхцөл олгох;

15.1.4. батлагдсан барилгажилтын төслийн дагуу орон сууцжуулах үйл ажиллагаанд захиалагчийн хяналт тавих;

15.1.5. гэр хорооллыг орон сууцжуулах нэгж талбарыг сонгон батлуулах;

15.1.6. орон сууцны барилга байгууламжийн зураг төсөл, баримт бичиг боловсруулах, магадлал хийж, баталгаажуулах.

15.2. Гэр хорооллыг орон сууцжуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэгч гэр хорооллыг орон сууцжуулах төслийн хүрээнд баригдсан орон сууцыг газар чөлөөлөлтийн нөхөх олговрын зориулалтаар зарцуулна.

¹⁰ Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2015 оны 25 дугаарт нийтлэгдсэн.

**ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ
ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ ТҮГЖРЭЛИЙН НӨЛӨӨЛЛИЙГ
БУУРУУЛАХ ТАЛААР ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН
ЧИГ ҮҮРЭГ, ОРОЛЦОГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ**

16 дугаар зүйл.Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны даргын чиг үүрэг

16.1.Замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах талаар Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны дарга дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

16.1.1.тогтвортой зорчилт хөдөлгөөний болон нийтийн тээврийг хөгжүүлэх урт, дунд хугацааны төлөвлөлтийг батлах;

16.1.2.нийслэлийн хүн амын төвлөрлийг сааруулах, замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах арга хэмжээний талаарх мэдээллийг Засгийн газарт тухай бүр танилцуулах;

16.1.3.нийслэлийн нутаг дэвсгэрт газар эзэмших, ашиглах эрх шинээр олгох, сунгах, барилга байгууламж барих, дахин төлөвлөх үйл ажиллагаанд хязгаарлалт тогтоох нийслэлийн Засаг даргын саналыг Засгийн газарт танилцуулж шийдвэрлүүлэх;

16.1.4.холбогдох төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагын ажлын уялдааг нэгдсэн удирдлагаар хангах;

16.1.5.төр, хувийн хэвшлийн түншлэл, гадаад, дотоодын хөрөнгө оруулалт, хамтын ажиллагааг хөгжүүлэх.

17 дугаар зүйл.Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын чиг үүрэг

17.1.Замын хөдөлгөөний түгжрэл, түүний нөлөөллийг бууруулах талаар нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

17.1.1.замын хөдөлгөөний түгжрэл, түүний нөлөөллийг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд шаардлагатай төсвийг тухайн жилийн орон нутгийн төсвийн төсөлд тусгаж, батлах;



17.1.2.замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах талаар нийслэлийн Засаг даргаас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнд хяналт тавих;

17.1.3.нийслэл хотод олгох тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарын дээд хязгаарыг нийслэлийн Засаг даргын саналыг үндэслэн тогтоох;

17.1.4.хуульд заасан бусад.

18 дугаар зүйл.Нийслэлийн Засаг даргын чиг үүрэг

18.1.Замын хөдөлгөөний түгжрэл, түүний нөлөөллийг бууруулах талаар нийслэлийн Засаг дарга дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

18.1.1.замын хөдөлгөөний түгжрэлээс үүссэн нийгэм, эдийн засаг, байгаль орчинд нөлөөлж байгаа нөлөөллийн талаар судалгаа хийж, олон нийтэд мэдээлэх;

18.1.2.замын хөдөлгөөний түгжрэлийн нөлөөллийг бууруулах үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог хангах;

18.1.3.иргэний явганаар зорчих зам, дэд бүтцийн хүртээмж, дугуйн замын сүлжээг сайжруулах, нэмэгдүүлэх;

18.1.4.замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай газрыг чөлөөлөх;

18.1.5.нийслэлийн нутаг дэвсгэрт газар эзэмших, ашиглах эрх шинээр олгох, сунгах, барилга байгууламж барих, дахин төлөвлөх үйл ажиллагаанд хязгаарлалт тогтоох саналыг эрх бүхий этгээдэд уламжлах;

18.1.6.энэ хуулийн 16.1.1-д заасан төлөвлөлтийн хэрэгжилтийг хангах;

18.1.7.замын хөдөлгөөний түгжрэлийн нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө баталж, хэрэгжүүлэх;

18.1.8.хуульд заасан бусад.

18.2.Нийслэлийн Засаг дарга Хот байгуулалтын тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан ерөнхий архитекторын эрх үүргийг гэрээний үндсэн дээр мэргэжлийн байгууллага, хуулийн этгээдээр гүйцэтгүүлж болно.

19 дүгээр зүйл. Нийслэлийн замын хөдөлгөөний удирдлага, зохион байгуулалтын асуудал хариуцсан байгууллага, түүний чиг үүрэг

19.1. Нийслэлийн замын хөдөлгөөний удирдлага, зохион байгуулалтын асуудал хариуцсан байгууллага нь нийслэлийн Засаг даргын дэргэд ажиллана.

19.2. Нийслэлийн замын хөдөлгөөний удирдлага, зохион байгуулалтын асуудал хариуцсан байгууллага замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

19.2.1. нийслэлийн замын хөдөлгөөний үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангах;

19.2.2. замын хөдөлгөөний ажиглалт, судалгаа, тооллого, мэдээлэлд үндэслэн хөдөлгөөнийг оновчтой, зохион байгуулах, хяналт тавих;

19.2.3. замын хөдөлгөөний түгжрэлийн нөхцөл байдлыг бүртгэх, боловсруулах, хяналт тавих, судалгаа хийх, эрх бүхий байгууллагыг мэдээллээр хангах;

19.2.4. замын хөдөлгөөний түгжрэлийн нөхцөл байдлын талаарх мэдээллийг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд¹¹ заасан журмын дагуу олон нийтэд мэдээлэх;

19.2.5. авто зогсоолын үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах, судалгаа хийж, түүний менежмент, нэгдсэн системийг хариуцан ажиллах.

20 дугаар зүйл. Иргэн, хуулийн этгээдийн эрх, үүрэг

20.1. Иргэн, хуулийн этгээд замын хөдөлгөөний түгжрэлийн нөлөөллийг бууруулах талаар дараах эрх эдэлнэ:

20.1.1. холбогдох хууль тогтоомжийг дагаж мөрдөхийг бусдаас шаардах;

20.1.2. замын хөдөлгөөний түгжрэл, саатлын шалтгаан, нөхцөлийг арилгуулах талаар холбогдох байгууллага, албан тушаалтанд хууль ёсны шаардлага тавих;

¹¹ Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2022 оны 06 дугаарт нийтлэгдсэн.



20.1.3.хууль тогтоомжид заасан бусад.

20.2.Иргэн, хуулийн этгээд замын хөдөлгөөний түгжрэлийн нөлөөллийг бууруулах талаар дараах үүрэг хүлээнэ:

20.2.1.замын хөдөлгөөний түгжрэлийн нөлөөллийг бууруулахтай холбогдсон хууль тогтоомжийг дагаж мөрдөх;

20.2.2.хуульд заасан бусад.

ТАВДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

21 дүгээр зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

21.1.Энэ хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй нь гэмт хэрэг, зөрчлийн шинжгүй бол албан тушаалтанд Төрийн албаны тухай хуульд¹² заасан хариуцлага хүлээлгэнэ.

21.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хуульд¹³ заасан хариуцлага хүлээлгэнэ.

22 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

22.1.Энэ хуулийг 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

¹² Төрийн албаны тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2018 оны 01 дугаарт нийтлэгдсэн.

¹³ Зөрчлийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2017 оны 24 дугаарт нийтлэгдсэн.

Модерн-Фольк-на-Хелл

Модерн-Фольк-на-Хелл 20 - 25 - 30

Модерн-Фольк-на-Хелл
Модерн-Фольк-на-Хелл
Модерн-Фольк-на-Хелл

Модерн-Фольк-на-Хелл
Модерн-Фольк-на-Хелл

Модерн-Фольк-на-Хелл

Модерн-Фольк-на-Хелл
Модерн-Фольк-на-Хелл
Модерн-Фольк-на-Хелл

Модерн-Фольк-на-Хелл
Модерн-Фольк-на-Хелл

Модерн-Фольк-на-Хелл
Модерн-Фольк-на-Хелл
Модерн-Фольк-на-Хелл

Модерн-Фольк-на-Хелл
Модерн-Фольк-на-Хелл

Модерн-Фольк-на-Хелл

Модерн-Фольк-на-Хелл
Модерн-Фольк-на-Хелл





МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 12 дугаар
сарын 07-ны өдөр

Улаанбаатар
хот

**МОНГОЛ УЛСЫН АВТОТЭЭВРИЙН
БОЛОН ӨӨРӨӨ ЯВАГЧ ХЭРЭГСЛИЙН
АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Монгол Улсын Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай заалт нэмсүгэй:

“

11	Цахилгаан тэжээлт автомашин	0-100 000	0-80 000
----	-----------------------------	-----------	----------

2 дугаар зүйл. Монгол Улсын Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“

3	Суудлын автомашин: а/ 2001 см ³ хүртэл б/ 2001-3001 см ³ хүртэл в/ 3001 см ³ болон түүнээс дээш	Улаанбаатар хот /Цилиндрийн багтаамжийн нэг см ³ тутамд төгрөгөөр/ 16-96 18-108 22-132	14-42 16-48 20-60
		Дархан-Уул, Орхон аймгийн төвийн сумд /Цилиндрийн багтаамжийн нэг см ³ тутамд төгрөгөөр/ 16-48 18-54 22-66	

3 дугаар зүйл. Монгол Улсын Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “татвар, гааль, зам, тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага” гэснийг “санхүү, төсвийн болон зам, тээврийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд” гэж өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 12 дугаар
сарын 07-ны өдөр

Улаанбаатар
хот

АГААРЫН БОХИРДЛЫН ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“7.3. Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслээс ялгарах нүүрсхүчлийн хийн төлбөрийг тэдгээрийн ангиллаас хамаарсан хувь, хэмжээгээр дараах байдлаар тогтооно:

Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн ангилал	CO ₂ хийн ялгарал /г/км/	Жилд ногдуулах төлбөр /төгрөгөөр/
А	121-180	3600
Б	181-250	4200
В	251-350	7000
Г	351-500	10000
Д	501-750	15000
Е	751-ээс дээш	19000

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

Модуль Folo_02 Нөдөл

2024 оны 6 сарын 20 - 2024 оны 6 сарын 20

Монгол Улсын Ерөнхий сайдын үйлдвэр

Монгол Улсын Ерөнхий сайдын үйлдвэр
Монгол Улсын Ерөнхий сайдын үйлдвэр

Монгол Улсын Ерөнхий сайдын үйлдвэр
Монгол Улсын Ерөнхий сайдын үйлдвэр

Монгол Улсын Ерөнхий сайдын үйлдвэр
Монгол Улсын Ерөнхий сайдын үйлдвэр

№	Төрөл	Хэмжээ	Төлбөр	Төлбөрийн төрөл	Төлбөрийн хэмжээ
1	Төлбөр	100000	100000	Төлбөр	100000
2	Төлбөр	2000	2000	Төлбөр	2000
3	Төлбөр	2000	2000	Төлбөр	2000
4	Төлбөр	2000	2000	Төлбөр	2000

Монгол Улсын Ерөнхий сайдын үйлдвэр

Монгол Улсын Ерөнхий сайдын үйлдвэр

Монгол Улсын Ерөнхий сайдын үйлдвэр



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 12 дугаар
сарын 07-ны өдөр

Улаанбаатар
хот

АВТОТЭЭВРИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Автотээврийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:

1/12 дугаар зүйлийн 12.5-12.7 дахь хэсэг:

“12.5. Таксинаас бусад нийтийн тээврийн үйлчилгээний төлбөрийн хувь хэмжээг энэ хуулийн 6.1.7-д заасан жишиг тарифт нийцүүлэн аймаг, нийслэлийн Засаг даргын саналыг үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно.

12.6. Энэ хуулийн 12.5-д заасан нийтийн тээврийн үйлчилгээний төлбөрийн орлогыг орон нутгийн төрийн сангийн дансанд төвлөрүүлэх бөгөөд зарцуулалтад эрх бүхий байгууллага, албан тушаалтан хяналт тавина.

12.7. Энэ хуулийн 12.6-д заасан орлогыг төвлөрүүлэхэд хяналт тавих ажлыг нээлттэй сонгон шалгаруулалтын үндсэн дээр хөндлөнгийн байгууллагаар гүйцэтгүүлж болно.”

2/15 дугаар зүйлийн 15.9, 15.10 дахь хэсэг:

“15.9. Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг дараах нөхцөл, шаардлагыг хангасан хуулийн этгээдэд олгоно:

15.9.1. нийтийн тээврийн үйлчилгээг шуурхай зохион байгуулах, жолооч, зорчигчдын аюулгүй байдлыг хангах дүрс бичлэгийн төхөөрөмжөөр тоноглогдсон, техникийн хяналтын үзлэгт хамрагдаж тэнцсэн нийтийн тээврийн хэрэгсэлтэй байх;

15.9.2. нийтийн тээврийн үйлчилгээг гүйцэтгэх мэргэшсэн жолооч, мэргэжлийн хүний нөөц, санхүүгийн чадавхтай байх;

15.9.3. техникийн оношилгоо, үйлчилгээний болон засвар, угаалгын байртай байх;

15.9.4. автотээврийн хэрэгсэл нь хөгжлийн бэрхшээлтэй иргэний аюулгүй, чөлөөтэй зорчих нөхцөлийг бүрдүүлсэн байх;

15.9.5.Монгол Улсын стандартад заасан шаардлага хангасан байх;

15.9.6.автотээврийн хэрэгсэл нь үйлдвэрлэснээс хойш 10-аас дээш жил ашиглагдаагүй байх;

15.9.7.татвар төлөгчөөр бүртгүүлсэн, татварын өргүй байх;

15.9.8.цахим төлбөрийн баримтын системд холбогдсон байх.

15.10.Такси үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг энэ хуулийн 15.9-д зааснаас гадна жолоочийг тогтсон тарифын дагуу үйлчилж байгаа эсэхийг шалгах хэмжилт-хяналтын төхөөрөмж, таних тэмдэгтэй автотээврийн хэрэгсэлтэй байх нөхцөл, шаардлага хангасан хуулийн этгээдэд олгоно.”

3/17¹ дүгээр зүйлийн 17^{1.5}-17^{1.8} дахь хэсэг:

“17^{1.5}.Нийслэлд олгох автотээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарын тооны дээд хязгаарыг нийслэлийн Засаг даргын саналыг үндэслэн нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батлах бөгөөд тус хязгаарт багтаан автотээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарыг энэ хуулийн 17^{1.2}-т заасан журмын дагуу олгоно.

17^{1.6}.Энэ хуулийн 17^{1.1}-д заасан автотээврийн хэрэгслийн бүртгэлийг нийслэлийн Засаг даргад шилжүүлж болно.

17^{1.7}.Энэ хуулийн 17^{1.5}-д заасан хязгаарт багтаан олгох автотээврийн хэрэгслийн төрөл, ангилал, иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагааны чиглэл, шалгуур үзүүлэлтийг нийслэлийн Засаг дарга батална.

17^{1.8}.Нийслэлд бүртгэлтэй автотээврийн хэрэгслийн өмчлөгч, эзэмшигч нь нийслэлийн оршин суугч байх бөгөөд автотээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарыг худалдах, бэлэглэх, барьцаалах замаар бусдад шилжүүлж болно. Автотээврийн хэрэгслийн өмчлөгч, эзэмшигч автотээврийн хэрэгслийг орон нутгийн бүртгэлд шилжүүлэн бүртгүүлсэн, эсхүл ашиглалтаас хасуулсан бол автотээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарыг өөр автотээврийн хэрэгсэлд ашиглаж болно.”

2 дугаар зүйл.Автотээврийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:



“15.1.Автотээврийн хэрэгслийн дугаар үйлдвэрлэх, автотээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх, аймаг, нийслэлийн нийтийн зорчигч тээвэр, таксины үйлчилгээг Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 5.3, 5.5, 5.12-т заасан тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд эрхэлнэ.”

3 дугаар зүйл.Автотээврийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.7 дахь хэсгийн “Тээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх ажил эрхлэхээр” гэснийг “Энэ хуулийн 15.1-д заасан ажил, үйлчилгээг эрхлэхээр” гэж өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Автотээврийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

5 дугаар зүйл.Энэ хуулийг Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 12 дугаар
сарын 07-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 13 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/13 дугаар зүйлийн 13.2.9 дэх заалт:

“13.2.9.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомж болон түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний акт зөрчсөнтэй холбогдуулан оногдуулсан торгох шийтгэл, авто зам, замын байгууламж ашигласны төлбөр, агаарын бохирдлын төлбөр, автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварыг хугацаанд нь төлөх.”

2/13 дугаар зүйлийн 13.5 дахь хэсэг:

“13.5.Иргэн, хуулийн этгээд энэ хуулийн 13.2.9, 22.4-т заасан үүргээ хугацаанд нь биелүүлээгүй бол автотээврийн хэрэгслийг замын хөдөлгөөнд оролцуулахыг хориглоно.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

Мэдэгдэл

2024 оны 12 сарын 16 өдөр

МОНГОЛЫН ХӨДӨӨ АЖ АХуйн яаманд

Хөдөө аж ахуйн яаманд
байрны тухай мэдээлэл
гэрээний үндсэн дээр

МОНГОЛЫН ХӨДӨӨ АЖ АХуйн яаманд байрны тухай мэдээлэл гэрээний үндсэн дээр

Хөдөө аж ахуйн яаманд байрны тухай мэдээлэл гэрээний үндсэн дээр

«Хөдөө аж ахуйн яаманд байрны тухай мэдээлэл гэрээний үндсэн дээр»

Хөдөө аж ахуйн яаманд байрны тухай мэдээлэл гэрээний үндсэн дээр

«Хөдөө аж ахуйн яаманд байрны тухай мэдээлэл гэрээний үндсэн дээр»

Хөдөө аж ахуйн яаманд байрны тухай мэдээлэл гэрээний үндсэн дээр

Хөдөө аж ахуйн яаманд байрны тухай мэдээлэл гэрээний үндсэн дээр

Хөдөө аж ахуйн яаманд байрны тухай мэдээлэл гэрээний үндсэн дээр



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 12 дугаар сарын 07-ны өдөр

Улаанбаатар хот

ХОТ, СУУРИН ГАЗРЫГ ДАХИН ХӨГЖҮҮЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн 3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 3.4 дэх хэсэг нэмсүгэй:

“3.4.Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулиар тусгайлан зохицуулснаас бусад харилцааг энэ хуулиар зохицуулж болно.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

Mongolian State Information Agency

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 10000, 10000-00000

Холбоо: 10000-00000
Телефон: 10000-00000
Э-мэйл: 10000-00000

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
Г.ЗАНДАНШАТАР

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 10000, 10000-00000
Холбоо: 10000-00000
Телефон: 10000-00000
Э-мэйл: 10000-00000

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 10000, 10000-00000
Холбоо: 10000-00000
Телефон: 10000-00000
Э-мэйл: 10000-00000

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 10000, 10000-00000
Холбоо: 10000-00000
Телефон: 10000-00000
Э-мэйл: 10000-00000

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 12 дугаар
сарын 07-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛ УЛААНБААТАР ХОТЫН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 22.1.13, 22.1.14 дэх заалт нэмсүгэй:

“22.1.13. харьяалах нутаг дэвсгэрийн замын хөдөлгөөнд ачааны, түгээлт, хүргэлтийн үйлчилгээний автомашиныг хязгаарлалттайгаар оролцуулах, дэмжлэг үзүүлэх журам батлах;

22.1.14. хотын нийтийн аж ахуйн үйлчилгээ үзүүлэх, түүнд хяналт тавих журам батлах.”

2 дугаар зүйл. Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсгийн “Улаанбаатар хотын Ерөнхий менежер” гэсний дараа “, эсхүл дүүргийн Засаг даргад” гэж, 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсгийн “Засгийн газар тогтооно.” гэсний дараа “Захирагчийн ажлын алба нь газар, хэлтэс, тасагтай байна.” гэж, 30 дугаар зүйлийн 30.4 дэх хэсгийн “авсан байна.” гэсний дараа “Дүүргийн удирдлага 14 хоногийн дотор санал өгөх бөгөөд тус хугацаанд санал ирүүлээгүй бол тусгайлан өгөх саналгүй гэж үзнэ.” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн дараах зүйл, хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг:

“9.1. Нийслэл хотын дүрэмд дараах харилцааг тусгаж болно:

- 9.1.1. ногоон байгууламжийн ашиглалт, хамгаалалт;
- 9.1.2. цэцэрлэгт хүрээлэн /парк/-ийн ашиглалт, хамгаалалт;
- 9.1.3. хотод тарьж ургуулж болох мод, бут, сөөг;
- 9.1.4. дуу, чимээний бохирдлын хяналт;
- 9.1.5. хүүхдийн тоглоомын талбай байгуулах, түүний ашиглалт, тохижилт;
- 9.1.6. нийтийн зориулалттай эд хөрөнгийн ашиглалт, хамгаалалт;



9.1.7.хөшөө, дурсгал, хүндэтгэлийн самбар байрлуулах;
9.1.8.хашаа, хайсны стандарт, түүнийг барих, ашиглах,
буулгах;

9.1.9.явган хүний болон дугуйн зам, талбай төлөвлөлт,
ашиглалт, хамгаалалт;

9.1.10.ашиглалтад орсон орон сууц, барилга
байгууламжийн нүүр тал /фасад/-д тавих шаардлага, өнгөний шийдэл;

9.1.11.зам дагуух барилга байгууламж, үйлчилгээ
эрхлэгчдийн гаднах орчны тохижилт, цэвэрлэгээ, үйлчилгээ;

9.1.12.барилга угсралтын үйл ажиллагаанд ашиглагдаж
байгаа тээврийн хэрэгслийн ариутгал, цэвэрлэгээ;

9.1.13.ерөнхий боловсролын сургуулийн эргүүл;
9.1.14.хотын оршин суугчийн соёл, хөршийн холбоо;
9.1.15.сургуулийн хүүхэд тээвэрлэх автобус;
9.1.16.нисгэгчгүй нисэх төхөөрөмж /дрон/ ашиглалт;
9.1.17.гудамж, талбайд олон нийтийг хамарсан арга
хэмжээг зохион байгуулах;

9.1.18.нийтийн тээврээр үйлчлүүлэх харилцаа;
9.1.19.зар сурталчилгаа, хаягжилт, гудамжны тоноглол;
9.1.20.нийтийн байрны ашиглалт, зохицуулалт;
9.1.21.алдагдсан эд зүйлсийн зохицуулалт;
9.1.22.нүхэн жорлонгийн шаардлага, ашиглалт.”

2/41 дүгээр зүйл:

“41 дүгээр зүйл.Тусгай бүсийн Захирагч

41.1.Тусгай бүсийг дагуул хотод байгуулсан тохиолдолд тусгай
бүсийн Захирагч нь тухайн дагуул хотын Захирагч байна.

41.2.Энэ хуулийн 41.1-д зааснаас бусад нутаг дэвсгэрт байгуулсан
тусгай бүсийн Захирагчийг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд
танилцуулснаар нийслэлийн Засаг дарга томилно.”

4 дүгээр зүйл.Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх
зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5 дахь хэсгийн “хүн
амын” гэснийг “хүн ам, барилгажилтын” гэж, 22 дугаар зүйлийн 22.1.13
дахь заалтын дугаарыг “22.1.15” гэж, 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсгийн
“хариуцсан газартай” гэснийг “хариуцсан байгууллагатай” гэж, 38 дугаар



зүйлийн 38.1 дэх хэсгийн “дагуул хотод” гэснийг “нийслэлийн нутаг дэвсгэр, дагуул хот болон бусад орон нутагт тухайн засаг захиргааны нэгжтэй тохиролцсоны үндсэн дээр” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл.Энэ хуулийг Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

᠑᠙᠑᠗ он ᠑᠘ дүгээр сар ᠒᠗-ны өдөр

᠑᠙᠑᠗ он ᠑᠘ дүгээр сар ᠒᠗-ны өдөр
᠑᠙᠑᠗ он ᠑᠘ дүгээр сар ᠒᠗-ны өдөр

Индриг Фолд оо Нөёл

᠑᠙᠑᠗ он ᠑᠘ дүгээр сар ᠒᠗-ны өдөр

᠑᠙᠑᠗ он ᠑᠘ дүгээр сар ᠒᠗-ны өдөр
᠑᠙᠑᠗ он ᠑᠘ дүгээр сар ᠒᠗-ны өдөр

᠑᠙᠑᠗ он ᠑᠘ дүгээр сар ᠒᠗-ны өдөр
᠑᠙᠑᠗ он ᠑᠘ дүгээр сар ᠒᠗-ны өдөр

᠑᠙᠑᠗ он ᠑᠘ дүгээр сар ᠒᠗-ны өдөр
᠑᠙᠑᠗ он ᠑᠘ дүгээр сар ᠒᠗-ны өдөр

᠑᠙᠑᠗ он ᠑᠘ дүгээр сар ᠒᠗-ны өдөр
᠑᠙᠑᠗ он ᠑᠘ дүгээр сар ᠒᠗-ны өдөр

᠑᠙᠑᠗ он ᠑᠘ дүгээр сар ᠒᠗-ны өдөр
᠑᠙᠑᠗ он ᠑᠘ дүгээр сар ᠒᠗-ны өдөр

᠑᠙᠑᠗ он ᠑᠘ дүгээр сар ᠒᠗-ны өдөр



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 12 дугаар
сарын 07-ны өдөр

Улаанбаатар
хот

НИЙСЛЭЛ ХОТЫН АЛБАН ТАТВАРЫН
ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Нийслэл хотын албан татварын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийн “7.2.1-7.2.4-т” гэснийг “7.2.1-7.2.6-д” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

Мөдөгж Фолд_02 НӨИ1

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ᠤᠨ ᠬᠤᠠᠭᠤᠯᠠᠭ ᠤᠯᠤᠰ

ᠨᠢᠶᠢᠰᠢᠯᠡᠯ ᠬᠣᠲᠤ ᠠᠯᠪᠠᠨ ᠲᠠᠲᠦ᠋᠋ᠷᠢ ᠲᠤᠬᠤ ᠬᠤᠠᠭᠤᠯᠠᠭ ᠲᠤᠬᠤ

ᠠᠨᠤᠯᠠᠭ ᠤᠯᠤᠰ-ᠤᠨ 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийн “7.2.1-7.2.4-т” гэснийг “7.2.1-7.2.6-д” гэж өөрчилсүгэй.

ᠡнэ хуулийг Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ᠤᠨ
ИХ ХУРЛЫН ДАРГА
Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 12 дугаар
сарын 07-ны өдөр

Улаанбаатар
хот

ХОТ БАЙГУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хот байгуулалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/9 дүгээр зүйлийн 9.1.7 дахь заалт:

“9.1.7.эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй барьсан, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийн шаардлагыг зөрчсөн барилга байгууламж, инженерийн дэд бүтцийг шилжүүлэх, албадан буулгах зэргээр орц, гарцыг гаргах арга хэмжээг авах.”

2/9 дүгээр зүйлийн 9.2-9.5 дахь хэсэг:

“9.2.Энэ хуулийн 9.1.7-д заасан барилга байгууламж, инженерийн дэд бүтцийг шилжүүлэх, албадан буулгахтай холбоотой зардлыг буруутай этгээдээр гаргуулна.

9.3.Энэ хуулийн 9.1.2-т заасан аймаг, нийслэлийн ерөнхий архитекторын сонгон шалгаруулалтад Барилгын тухай хуулийн 44.3-т заасан мэргэшлийн зэрэгтэй архитектор, хот төлөвлөлтийн мэргэжилтэн, эсхүл мэргэжлийн байгууллага, хуулийн этгээд оролцож болно.

9.4.Аймаг, нийслэлийн ерөнхий архитекторын эрх, үүргийг мэргэжлийн байгууллага, хуулийн этгээд хэрэгжүүлэх бол аймаг, нийслэлийн Засаг даргатай гэрээ байгуулна.

9.5.Энэ хуулийн 9.4-т заасан мэргэжлийн байгууллага, хуулийн этгээд нь энэ хууль болон гэрээнд заасан эрх, үүргийг хэрэгжүүлж, хариуцлага хүлээнэ.”

2 дугаар зүйл. Хот байгуулалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.6.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“12.6.3.төлөвлөгөөнд хамааруулсан нийт газар нутгийн болон барилга барих зориулалтаар олгосон газрын нийт талбайн 20-иос доошгүй хувь нь цэцэрлэг, ногоон байгууламж, 20-иос доошгүй хувь нь авто зогсоол байна. Хог хаягдлыг цуглуулах, ангилан ялгах, тээвэрлэх зориулалт бүхий талбайтай байна.”



3 дугаар зүйл.Хот байгуулалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.8 дахь хэсгийн “70 хувиас илүүгүй” гэснийг “60 хувиас илүүгүй буюу төлөвлөгөөнд хамааруулсан нийт газар нутгийн болон барилга барих зориулалтаар олгосон газрын нийт талбайн 20-иос доошгүй хувь нь цэцэрлэг, ногоон байгууламж, 20-иос доошгүй хувь нь авто зогсоол” гэж өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

Мөрдөгч Голд Ог Нөм

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ
ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠳᠠᠷᠭ᠋᠎ᠠ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠳᠠᠷᠭ᠋᠎ᠠ
ᠶ᠋ᠢᠨ ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠳᠠᠷᠭ᠋᠎ᠠ

ᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠳᠠᠷᠭ᠋᠎ᠠ...ᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠳᠠᠷᠭ᠋᠎ᠠ
ᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠳᠠᠷᠭ᠋᠎ᠠ ᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠳᠠᠷᠭ᠋᠎ᠠ
ᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠳᠠᠷᠭ᠋᠎ᠠ ᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠳᠠᠷᠭ᠋᠎ᠠ

ᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠳᠠᠷᠭ᠋᠎ᠠ

ᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠳᠠᠷᠭ᠋᠎ᠠ ᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠳᠠᠷᠭ᠋᠎ᠠ
ᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠳᠠᠷᠭ᠋᠎ᠠ ᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠳᠠᠷᠭ᠋᠎ᠠ
ᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠳᠠᠷᠭ᠋᠎ᠠ ᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠳᠠᠷᠭ᠋᠎ᠠ
ᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠳᠠᠷᠭ᠋᠎ᠠ ᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠳᠠᠷᠭ᠋᠎ᠠ

ᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠳᠠᠷᠭ᠋᠎ᠠ

ᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠳᠠᠷᠭ᠋᠎ᠠ ᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠳᠠᠷᠭ᠋᠎ᠠ
ᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠳᠠᠷᠭ᠋᠎ᠠ ᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠳᠠᠷᠭ᠋᠎ᠠ
ᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠳᠠᠷᠭ᠋᠎ᠠ ᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠳᠠᠷᠭ᠋᠎ᠠ

ᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠳᠠᠷᠭ᠋᠎ᠠ ᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠳᠠᠷᠭ᠋᠎ᠠ
ᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠳᠠᠷᠭ᠋᠎ᠠ ᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠳᠠᠷᠭ᠋᠎ᠠ
ᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠳᠠᠷᠭ᠋᠎ᠠ ᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠳᠠᠷᠭ᠋᠎ᠠ



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 12 дугаар
сарын 07-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Зөвшөөрлийн тухай хуульд доор дурдсан агуулгатай хэсэг, заалт нэмсүгэй:

1/3.4 дүгээр зүйлийн 3, 4 дэх хэсэг:

“3.Энэ хуулийн 8.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 3.9, 3.10, 3.11, 3.12, 3.13, 3.14, 3.15, 3.16, 3.17, 3.18, 3.19, 3.20, 3.21, 3.22 дахь заалт, 14 дэх хэсгийн 14.25, 14.28, 14.32, 14.33, 14.34 дэх заалтад тусгагдсан тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд, тусгай зөвшөөрөл эзэмшигч, аймаг, нийслэлийн Засаг дарга гурвалсан гэрээ байгуулж ажиллана.

4.Энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан гэрээний загварыг тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд болон аймаг, нийслэлийн Засаг дарга хамтран батална.”

2/8.1 дүгээр зүйлийн 5.12 дахь заалт:

Тусгай зөвшөөрөл	Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд
5.12.орон нутгийн, хот доторх болон хот орчмын нийтийн зорчигч тээвэр, такси үйлчилгээ эрхлэх	Аймаг, нийслэлийн Засаг дарга

3/9.6 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

“2.Энэ хуулийн 3.4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 3 сарын дотор уг хэсэгт заасан гэрээг нөхөн байгуулна.”

2 дугаар зүйл. Энэ хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 5.12 дахь заалтад заасан нийтийн зорчигч тээвэр, такси үйлчилгээг тусгай зөвшөөрөлтэйгээр эрхлэх тухай зохицуулалтыг 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

Мэдээлэл ба Файл

Мэдээлэл ба Файл

Мэдээлэл ба Файл № 02 - 2024 он

Мэдээлэл ба Файл
Мэдээлэл ба Файл

Мэдээлэл ба Файл № 02 - 2024 он

Мэдээлэл ба Файл № 02 - 2024 он

Мэдээлэл ба Файл № 02 - 2024 он

Мэдээлэл ба Файл № 02 - 2024 он

Мэдээлэл ба Файл № 02 - 2024 он

Мэдээлэл ба Файл № 02 - 2024 он	Мэдээлэл ба Файл № 02 - 2024 он
---------------------------------	---------------------------------

Мэдээлэл ба Файл № 02 - 2024 он

Мэдээлэл ба Файл № 02 - 2024 он

Мэдээлэл ба Файл № 02 - 2024 он

Мэдээлэл ба Файл № 02 - 2024 он

Мэдээлэл ба Файл № 02 - 2024 он

Мэдээлэл ба Файл № 02 - 2024 он



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 12 дугаар
сарын 07-ны өдөр

Улаанбаатар
хот

ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 13.7 дахь хэсэг нэмсүгэй:

“13.7.Орон сууцны тухай хуулийн 15.1, 15.3-т заасныг зөрчиж нийтийн зориулалттай орон сууцны хийц, бүтээц, зориулалтыг өөрчилсөн бол холбогдох өөрчлөлтийг эрхийн улсын бүртгэлд бүртгэхийг хориглоно.”

2 дугаар зүйл. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“9 дүгээр зүйл. Эрхийн улсын бүртгэлд тусгах үл хөдлөх эд хөрөнгийн үнэ

9.1. Эрхийн улсын бүртгэлд тусгах газрын хязгаарлагдмал эрх, гэрээгээр ашиглах эрх, үл хөдлөх эд хөрөнгийн үнийг дараах тохиолдолд доор дурдсан дэс дарааллаар тодорхойлно:

9.1.1. газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийг анх удаа эрхийн улсын бүртгэлд бүртгэхэд тухайн хөрөнгийн захиалгын гэрээнд заасан үнэ, захиалгын гэрээнд заасан үнэ байхгүй бол батлагдсан төсөвт өртгөөр тодорхойлогдсон үнэ;

9.1.2. газрын эрхийг анх удаа эрхийн улсын бүртгэлд бүртгэхэд эрх бүхий байгууллагаас тогтоосон суурь үнэ, суурь үнэ байхгүй бол дуудлага худалдааны үнэ;

9.1.3. өмчлөх эрх болон түүнтэй холбогдсон эд хөрөнгийн бусад эрх, газрын эрхийг худалдах, эсхүл шилжүүлэн бүртгүүлэх тохиолдолд гэрээ, хэлцэл, эсхүл эрх шилжүүлсэн шийдвэрт тусгагдсан үнэ;

9.1.4. газрын эрх, үл хөдлөх эд хөрөнгийг барьцаалах тохиолдолд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүртгэгдсэн барьцааны гэрээ, эсхүл барьцаалбарт тусгагдсан тухайн эд хөрөнгийн барьцааны үнэ;

9.1.5. үнийн талаар өөрчлөлт орсныг эрхийн улсын бүртгэлд бүртгэхэд хуульд заасны дагуу хөрөнгийн үнэлгээ хийх эрх бүхий этгээдээр тогтоолгосон үнэ.

9.2.Мэдүүлэг гаргагч эд хөрөнгийн үнийг бодитой мэдүүлнэ.

9.3.Энэ хуулийн 9.1.5-д зааснаас бусад тохиолдолд энэ хуулийн 9.1.3, 9.1.4-т заасан үнийг хамгийн сүүлд бүртгэгдсэн үнээс бууруулж бүртгэхгүй.”

3 дугаар зүйл.Энэ хуулийг Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

᠑᠙᠙᠘ оны ᠑᠒ сарын ᠑᠗-ны Улсын Их Хурлын Төрийн захираагчийн зарлиг

᠑᠙᠙᠙ оны ᠑᠒ сарын ᠑᠗-ны Улсын Их Хурлын Төрийн захираагчийн зарлиг

᠑᠙᠙᠙ оны ᠑᠒ сарын ᠑᠗-ны Улсын Их Хурлын Төрийн захираагчийн зарлиг

᠑᠙᠙᠙ оны ᠑᠒ сарын ᠑᠗-ны Улсын Их Хурлын Төрийн захираагчийн зарлиг

᠑᠙᠙᠙ оны ᠑᠒ сарын ᠑᠗-ны Улсын Их Хурлын Төрийн захираагчийн зарлиг

« ᠑᠙᠙᠙ оны ᠑᠒ сарын ᠑᠗-ны Улсын Их Хурлын Төрийн захираагчийн зарлиг

᠑᠙᠙᠙ оны ᠑᠒ сарын ᠑᠗-ны Улсын Их Хурлын Төрийн захираагчийн зарлиг

᠑᠙᠙᠙ оны ᠑᠒ сарын ᠑᠗-ны Улсын Их Хурлын Төрийн захираагчийн зарлиг



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 12 дугаар
сарын 07-ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Төрийн албаны тухай хуулийн 41 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 41.3 дахь хэсэг нэмсүгэй:

“41.3.Ажлын зайлшгүй шаардлагатайгаас бусад тохиолдолд төрийн албан хаагчийг долоо хоногийн ажлын нэг өдөр зайнаас ажиллуулна.”

2 дугаар зүйл.Төрийн албаны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.9 дэх заалтын “орлогч” гэсний дараа “, Улаанбаатар хотын Ерөнхий менежер” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл.Төрийн албаны тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.3 дахь хэсгийн дугаарыг “41.4” гэж өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Төрийн албаны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсгийн “удирдах” гэснийг хассугай.

5 дугаар зүйл.Энэ хуулийг Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

Илдэрдэ Фолю да Хөл

Мэргэжлээр дамжин хүлээн авч

дээрх үйлдлийг хийж авч үзсэн

Хүндэтгэсэн болон
Мэргэжлээр дамжин хүлээн авч
үйлдлийг хийж авч үзсэн

1. Өөрийн үйлдлийг үргэлжлүүлж байгаа болон үйлдлийг зогсооно гэж үздэг үү?

«Тийэвч ээ, Өөрийн үйлдлийг үргэлжлүүлж байгаа болон үйлдлийг зогсооно гэж үздэг үү?»

2. Өөрийн үйлдлийг үргэлжлүүлж байгаа болон үйлдлийг зогсооно гэж үздэг үү?

3. Өөрийн үйлдлийг үргэлжлүүлж байгаа болон үйлдлийг зогсооно гэж үздэг үү?

4. Өөрийн үйлдлийг үргэлжлүүлж байгаа болон үйлдлийг зогсооно гэж үздэг үү?

5. Өөрийн үйлдлийг үргэлжлүүлж байгаа болон үйлдлийг зогсооно гэж үздэг үү?

Мэргэжлээр дамжин хүлээн авч үйлдлийг хийж авч үзсэн

Мэргэжлээр дамжин хүлээн авч үйлдлийг хийж авч үзсэн



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 12 дугаар
сарын 07-ны өдөр

Улаанбаатар
хот

ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 46.5.10 дахь заалт нэмсүгэй:

“46.5.10.авто замын тэмдэг, тэмдэглэлийг шинээр байршуулах, шинэчлэх, засварлах.”

2 дугаар зүйл. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.5.10 дахь заалтын дугаарыг “46.5.11” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠬᠤᠷᠭᠢᠨ ᠳᠠᠷᠭ᠎ᠠ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠬᠤᠷᠭᠢᠨ ᠳᠠᠷᠭ᠎ᠠ
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠬᠤᠷᠭᠢᠨ ᠳᠠᠷᠭ᠎ᠠ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠬᠤᠷᠭᠢᠨ ᠳᠠᠷᠭ᠎ᠠ
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠬᠤᠷᠭᠢᠨ ᠳᠠᠷᠭ᠎ᠠ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠬᠤᠷᠭᠢᠨ ᠳᠠᠷᠭ᠎ᠠ
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠬᠤᠷᠭᠢᠨ ᠳᠠᠷᠭ᠎ᠠ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠬᠤᠷᠭᠢᠨ ᠳᠠᠷᠭ᠎ᠠ
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠬᠤᠷᠭᠢᠨ ᠳᠠᠷᠭ᠎ᠠ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠬᠤᠷᠭᠢᠨ ᠳᠠᠷᠭ᠎ᠠ
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠬᠤᠷᠭᠢᠨ ᠳᠠᠷᠭ᠎ᠠ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠬᠤᠷᠭᠢᠨ ᠳᠠᠷᠭ᠎ᠠ
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠬᠤᠷᠭᠢᠨ ᠳᠠᠷᠭ᠎ᠠ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 12 дугаар
сарын 07-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 35.2 дахь хэсэг нэмсүгэй:

“35.2. Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах журмыг батална:

35.2.1. амьтны хүрээлэн ажиллуулах журам;

35.2.2. мал аж ахуй эрхлэхийг хориглох бүсийн хил хязгаарыг тогтоох, хориглосон бүсэд нэвтэрсэн малыг түр хадгалах, түүнтэй холбогдон гарсан зардлыг нөхөн төлүүлэх журам;

35.2.3. оршуулгын үйл ажиллагаа эрхлэх, зохион байгуулах, зөвшөөрөлтэй оршуулгын газар болон зөвшөөрөлгүй газар оршуулсан шарилыг шилжүүлэх журам;

35.2.4. нийтийн эзэмшлийн гудамж, талбайн гэрэлтүүлэг, кабелийн шугамын ашиглалт, үйлчилгээний журам;

35.2.5. инженерийн бэлтгэл ажлын төлөвлөлт, ашиглалт, хамгаалалтын журам.”

2 дугаар зүйл. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“67.2. Засаг даргын тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг Засгийн газраас нэг бүрчлэн буюу нэг маягаар тогтоох бөгөөд нийслэлийн Засаг даргын тамгын газар нь газар, хэлтэс, тасагтай, аймаг, сум, дүүргийн Засаг даргын тамгын газар нь хэлтэс, тасагтай байна.”

3 дугаар зүйл. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2 дахь хэсгийн дугаарыг “35.3” гэж өөрчилсүгэй.



4 дүгээр зүйл.Энэ хуулийг Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

Идегдэл Фолд ол Нөдл

᠑᠙᠑᠗ оны ᠑᠒ дүгээр сарын ᠒᠑ - ᠒᠙

МОНГОЛ УЛСЫН

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН
ДАРГА
Г.ЗАНДАНШАТАР
МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН
ДАРГА
Г.ЗАНДАНШАТАР

᠑᠒᠑᠗ оны ᠑᠒ дүгээр сарын ᠒᠑ - ᠒᠙
МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН
ДАРГА
Г.ЗАНДАНШАТАР

᠑᠒᠑᠗ оны ᠑᠒ дүгээр сарын ᠒᠑ - ᠒᠙
МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН
ДАРГА
Г.ЗАНДАНШАТАР

᠑᠒᠑᠗ оны ᠑᠒ дүгээр сарын ᠒᠑ - ᠒᠙
МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН
ДАРГА
Г.ЗАНДАНШАТАР

᠑᠒᠑᠗ оны ᠑᠒ дүгээр сарын ᠒᠑ - ᠒᠙
МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН
ДАРГА
Г.ЗАНДАНШАТАР

᠑᠒᠑᠗ оны ᠑᠒ дүгээр сарын ᠒᠑ - ᠒᠙
МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН
ДАРГА
Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 12 дугаар
сарын 07-ны өдөр

Улаанбаатар
хот

УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 29.1.14 дэх заалт нэмсүгэй:

“29.1.14.орон нутгийн, хот доторх болон хот орчмын нийтийн зорчигч тээвэр, такси үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 3 000 000-10 000 000 төгрөг.”

2 дугаар зүйл. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийн “29.1.12,” гэсний дараа “29.1.14,” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“29.1.6.автотээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх ажил эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 5 000 000-15 000 000 төгрөг;”

4 дүгээр зүйл. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийн “35.2-35.5” гэснийг “35.4, 35.5” гэж өөрчилсүгэй.

5 дугаар зүйл. Энэ хуулийг Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

Истифодадорнинг аҳоли

№ 3/2018 й. 6-қ. Кўрсаткичнинг 2018 й. 6-қ.

Аҳолининг 2018 й. 6-қ. Кўрсаткичнинг
2018 й. 6-қ. Кўрсаткичнинг 2018 й. 6-қ.

2018 й. 6-қ. Кўрсаткичнинг 2018 й. 6-қ. Кўрсаткичнинг 2018 й. 6-қ. Кўрсаткичнинг 2018 й. 6-қ.

2018 й. 6-қ. Кўрсаткичнинг 2018 й. 6-қ. Кўрсаткичнинг 2018 й. 6-қ. Кўрсаткичнинг 2018 й. 6-қ.

2018 й. 6-қ. Кўрсаткичнинг 2018 й. 6-қ. Кўрсаткичнинг 2018 й. 6-қ. Кўрсаткичнинг 2018 й. 6-қ.

2018 й. 6-қ. Кўрсаткичнинг 2018 й. 6-қ. Кўрсаткичнинг 2018 й. 6-қ. Кўрсаткичнинг 2018 й. 6-қ.

2018 й. 6-қ. Кўрсаткичнинг 2018 й. 6-қ. Кўрсаткичнинг 2018 й. 6-қ. Кўрсаткичнинг 2018 й. 6-қ.

2018 й. 6-қ. Кўрсаткичнинг 2018 й. 6-қ. Кўрсаткичнинг 2018 й. 6-қ. Кўрсаткичнинг 2018 й. 6-қ.

2018 й. 6-қ. Кўрсаткичнинг 2018 й. 6-қ. Кўрсаткичнинг 2018 й. 6-қ. Кўрсаткичнинг 2018 й. 6-қ.

Истифодадорнинг аҳоли
2018 й. 6-қ. Кўрсаткичнинг 2018 й. 6-қ. Кўрсаткичнинг 2018 й. 6-қ. Кўрсаткичнинг 2018 й. 6-қ.



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 12 дугаар
сарын 07-ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 23.6.11 дэх заалт нэмсүгэй:

“23.6.11.Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулийн 6.2-т заасны дагуу нэмэгдүүлж ногдуулах албан татвар.”

2 дугаар зүйл.Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.8.16 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“23.8.16.энэ хуулийн 23.6.11-т зааснаас бусад үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар.”

3 дугаар зүйл.Энэ хуулийг Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

Индрига Голд_Оа Нолл

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠠᠭᠤᠯᠠᠭᠤᠯᠤᠰ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ
ᠶ᠋ᠢᠨᠬᠤᠭᠣᠯᠠᠭᠤᠯᠤᠰ

ᠲᠥᠰᠦᠪᠢᠶ᠋ᠢᠨ ᠲᠤᠬᠤᠢ
ᠬᠤᠠᠭᠤᠯᠠᠭᠤᠯᠤᠰ

ᠲᠥᠰᠦᠪᠢᠶ᠋ᠢᠨ ᠲᠤᠬᠤᠢ
ᠬᠤᠠᠭᠤᠯᠠᠭᠤᠯᠤᠰ

ᠲᠥᠰᠦᠪᠢᠶ᠋ᠢᠨ ᠲᠤᠬᠤᠢ
ᠬᠤᠠᠭᠤᠯᠠᠭᠤᠯᠤᠰ

ᠲᠥᠰᠦᠪᠢᠶ᠋ᠢᠨ ᠲᠤᠬᠤᠢ
ᠬᠤᠠᠭᠤᠯᠠᠭᠤᠯᠤᠰ

ᠲᠥᠰᠦᠪᠢᠶ᠋ᠢᠨ ᠲᠤᠬᠤᠢ
ᠬᠤᠠᠭᠤᠯᠠᠭᠤᠯᠤᠰ

ᠲᠥᠰᠦᠪᠢᠶ᠋ᠢᠨ ᠲᠤᠬᠤᠢ
ᠬᠤᠠᠭᠤᠯᠠᠭᠤᠯᠤᠰ



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 12 дугаар
сарын 07-ны өдөр

Улаанбаатар
хот

ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 6.2, 6.3 дахь хэсэг нэмсүгэй:

“6.2. Хот байгуулалтын тухай хуулийн 12.6.3, 12.8-д заасан цэцэрлэг, ногоон байгууламж, авто зогсоолын шаардлага хангаагүй үл хөдлөх эд хөрөнгөд ногдуулах албан татварын хувь, хэмжээг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал энэ хуулийн 6.1-д заасны дагуу тогтоосон хувь, хэмжээг 1 хүртэл хувиар нэмэгдүүлэн тогтоож болно.

6.3. Энэ хуулийн 6.2-т заасныг хэрэгжүүлэх журмыг улсын бүртгэлийн болон татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга хамтран батална.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

Модуль Фолло_02 Нөдөл

Арсны үндэсний судалгаа

2024 оны 02 сарын 09 өдөр /Арсны үндэсний судалгаа

Арсны үндэсний судалгаа /Арсны үндэсний судалгаа
Арсны үндэсний судалгаа /Арсны үндэсний судалгаа
Арсны үндэсний судалгаа /Арсны үндэсний судалгаа

Арсны үндэсний судалгаа /Арсны үндэсний судалгаа
Арсны үндэсний судалгаа /Арсны үндэсний судалгаа
Арсны үндэсний судалгаа /Арсны үндэсний судалгаа

Арсны үндэсний судалгаа /Арсны үндэсний судалгаа
Арсны үндэсний судалгаа /Арсны үндэсний судалгаа
Арсны үндэсний судалгаа /Арсны үндэсний судалгаа

Арсны үндэсний судалгаа /Арсны үндэсний судалгаа
Арсны үндэсний судалгаа /Арсны үндэсний судалгаа
Арсны үндэсний судалгаа /Арсны үндэсний судалгаа

Арсны үндэсний судалгаа /Арсны үндэсний судалгаа
Арсны үндэсний судалгаа /Арсны үндэсний судалгаа
Арсны үндэсний судалгаа /Арсны үндэсний судалгаа

Арсны үндэсний судалгаа /Арсны үндэсний судалгаа
Арсны үндэсний судалгаа /Арсны үндэсний судалгаа



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 12 дугаар
сарын 07-ны өдөр

Улаанбаатар
хот

ГААЛИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн 17 дугаар зүйлд заасан байршилд газар чөлөөлөлтийн нөхөх олговрын зориулалтаар орон сууцны барилга байгууламж шинээр барихад шаардагдах гэр хорооллыг орон сууцжуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэгчийн импортоор оруулж байгаа барилгын материал, машин механизмыг гаалийн албан татвараас 2028 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал чөлөөлсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуульд заасан барилгын материал, машин механизмын жагсаалт, тоо хэмжээг “Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем /БТКУС/”-ийн ангиллын дагуу Засгийн газар батална.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 12 дугаар
сарын 07-ны өдөр

Улаанбаатар
хот

ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 22.1.10 дахь заалт нэмсүгэй:

“22.1.10.гэр хорооллыг орон сууцжуулах ажилд зориулан гэрээний дагуу газар эзэмших, ашиглах, өмчлөх эрхээ гэр хорооллыг орон сууцжуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэгч байгууллагад борлуулсан, шилжүүлснээс олсон орлого.”

2 дугаар зүйл. Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.5 дахь заалтын “Засгийн газар,” гэсний дараа “нийслэл,” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийн 1 дүгээр зүйл буюу Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.10 дахь заалтыг Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн 2028 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд дагаж мөрдөнө.

4 дүгээр зүйл. Энэ хуулийн 2 дугаар зүйлийг Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

Мэдээлэл ба танилцуулга

Мэдээлэл ба танилцуулга

Мэдээлэл ба танилцуулга

Мэдээлэл ба танилцуулга
Мэдээлэл ба танилцуулга
Мэдээлэл ба танилцуулга

Мэдээлэл ба танилцуулга
Мэдээлэл ба танилцуулга
Мэдээлэл ба танилцуулга

Мэдээлэл ба танилцуулга
Мэдээлэл ба танилцуулга
Мэдээлэл ба танилцуулга

Мэдээлэл ба танилцуулга
Мэдээлэл ба танилцуулга
Мэдээлэл ба танилцуулга

Мэдээлэл ба танилцуулга
Мэдээлэл ба танилцуулга
Мэдээлэл ба танилцуулга

Мэдээлэл ба танилцуулга
Мэдээлэл ба танилцуулга
Мэдээлэл ба танилцуулга

Мэдээлэл ба танилцуулга

Мэдээлэл ба танилцуулга



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 12 дугаар
сарын 07-ны өдөр

Улаанбаатар
хот

АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 22.5.18, 22.5.19 дэх заалт нэмсүгэй:

“22.5.18.гэр хорооллыг орон сууцжуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэгч байгууллагын тухайн үйл ажиллагааны орлогод ногдох албан татварыг 90 хувиар;

22.5.19.гэр хорооллыг орон сууцжуулах ажилд зориулан гэрээний дагуу газар эзэмших, ашиглах, өмчлөх эрхээ гэр хорооллыг орон сууцжуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэгч байгууллагад борлуулсан, шилжүүлснээс олсон орлого.”

2 дугаар зүйл. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.1 дэх заалтын “Засгийн газар,” гэсний дараа “нийслэл,” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийн 1 дүгээр зүйл буюу Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5.18, 22.5.19 дэх заалтыг Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн 2028 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд дагаж мөрдөнө.

4 дүгээр зүйл. Энэ хуулийн 2 дугаар зүйлийг Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 12 дугаар
сарын 07-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Зөрчлийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг нэмсүгэй:

1/4.2 дугаар зүйлийн 5 дахь хэсэг:

“5.Хүн, хуулийн этгээд энэ хуулийн 7.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 11.19 дүгээр зүйлийн 10 дахь хэсэг, 14.4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 14.7 дугаар зүйлд заасан зөрчил үйлдэж торгох шийтгэлийг хугацаанд нь төлөөгүй нь энэ хуулийн 3.4 дүгээр зүйлийн 8 дахь хэсэгт заасны дагуу автотээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарлах үндэслэл болно.”

2/6.29 дүгээр зүйл:

“6.29 дүгээр зүйл.Оршуулгын үйл ажиллагааны журам зөрчих

1.Оршуулгын үйл ажиллагаа эрхлэх, зохион байгуулах, зөвшөөрөлтэй оршуулгын газар болон зөвшөөрөлгүй газар оршуулсан шарилыг шилжүүлэх журам зөрчсөн бол хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

3/6.30 дугаар зүйл:

“6.30 дугаар зүйл.Нийслэл Улаанбаатар хотод мөрдөх хууль, дүрэм, журам зөрчих

1.Нийслэл хотын дүрэм зөрчсөн бол хүнийг хорин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2.Авто зогсоолын нэгдсэн удирдлагын цахим системд холбогдоогүй, стандартын шаардлага хангаагүй авто зогсоол ажиллуулсан бол зөрчлийг арилгуулж, хууль зөрчиж олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.



3.Мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүсэд журам зөрчиж мал нэвтрүүлсэн бол хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

4.Зөвшөөрөлгүй нийтийн тээвэр, таксины үйлчилгээ эрхэлсэн бол хүнийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

4/7.6 дугаар зүйлийн 9 дэх хэсэг:

“9.Амьтны хүрээлэн ажиллуулахад тавигдах шаардлагыг зөрчсөн бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

5/14.4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг:

“3.Авто зам, замын байгууламж ашигласны төлбөрийг хугацаанд нь төлөөгүй бол төлбөл зохих төлбөрийг нөхөн төлүүлж, хүнийг хорин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

2 дугаар зүйл.Зөрчлийн тухай хуулийн 12.5 дугаар зүйлийн 1.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“1.2.хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд хамааруулсан нийт газар нутгийн болон барилга барих зориулалтаар олгосон газрын нийт талбайн 20-иос доошгүй хувь нь цэцэрлэг, ногоон байгууламж, 20-иос доошгүй хувь нь авто зогсоолтой байх, хог хаягдлыг цуглуулах, ангилан ялгах, тээвэрлэх зориулалт бүхий талбайтай байх;”

3 дугаар зүйл.Зөрчлийн тухай хуулийн 12.5 дугаар зүйлийн 1.4 дэх заалтын “70 хувиас” гэснийг “60 хувиас” гэж, мөн заалтын “нэг мянган” гэснийг “таван мянган” гэж, “арван мянган” гэснийг “тавин мянган” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

История Фольклора

История Фольклора

История Фольклора

История Фольклора

История Фольклора

История Фольклора

История Фольклора

История Фольклора

История Фольклора

История Фольклора

История Фольклора



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 12 дугаар
сарын 07-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.6 дахь заалтын “6.5 дугаар зүйлийн 11 дэх хэсэг,” гэсний дараа “6.30 дугаар зүйлийн 1, 3 дахь хэсэг,” гэж, 6.8 дахь заалтын “6.28 дугаар зүйлийн 5 дахь хэсэг,” гэсний дараа “6.29 дүгээр зүйл, 6.30 дугаар зүйлийн 1, 3, 4 дэх хэсэг, 7.6 дугаар зүйлийн 9 дэх хэсэг,” гэж, 6.12 дахь заалтын “11.24 дүгээр зүйл,” гэсний дараа “14.4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг,” гэж, 6.34 дэх заалтын “Зөрчлийн тухай хуулийн” гэсний дараа “6.30 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг,” гэж, 6.35 дахь заалтын “6.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг,” гэсний дараа “6.30 дугаар зүйлийн 1, 2, 4 дэх хэсэг,” гэж, 6.37 дахь заалтын “6.24 дүгээр зүйл,” гэсний дараа “6.30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг,” гэж, 6.38 дахь заалтын “6.14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг,” гэсний дараа “6.30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг,” гэж, 6.39 дэх заалтын “6.19,” гэсний дараа “6.30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг,” гэж, 6.44 дэх заалтын “6.15,” гэсний дараа “7.6 дугаар зүйлийн 9 дэх хэсэг,” гэж, 6.46 дахь заалтын “6.18 дугаар зүйлийн 5, 6 дахь хэсэг,” гэсний дараа “6.30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг,” гэж, 6.50 дахь заалтын “Зөрчлийн тухай хуулийн” гэсний дараа “6.30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг,” гэж, 6.51 дэх заалтын “6.2,” гэсний дараа “6.30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг,” гэж, 6.59 дэх заалтын “6.1 дүгээр зүйлийн 1, 3, 6 дахь хэсэг,” гэсний дараа “6.29 дүгээр зүйл, 6.30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 7.6 дугаар зүйлийн 9 дэх хэсэг,” гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 12 дугаар
сарын 07-ны өдөр

Улаанбаатар
хот

ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Газрын тухай хуульд доор дурдсан агуулгатай хэсэг, заалт нэмсүгэй:

1/16 дугаар зүйлийн 16.1.17, 16.1.18 дахь заалт:

“16.1.17.нийтийн эдэлбэр газар;
16.1.18.нийслэл хотын эдийн засгийн тусгай бүс.”

2/16 дугаар зүйлийн 16.4, 16.5 дахь хэсэг:

“16.4.Энэ хуулийн 16.1.18-д заасан зориулалтаар улсын тусгай хэрэгцээнд авсан газар нь бусад аймаг болон хэд хэдэн аймаг, сумын нутаг дэвсгэрт байж болно.

16.5.Энэ хуулийн 16.1.18-д заасан зориулалтаар улсын тусгай хэрэгцээнд авсан газарт хэрэгжүүлэх арга хэмжээ, хөрөнгө оруулалтын талаар тохиролцож Нийслэлийн Засаг дарга тухайн нутаг дэвсгэрийн Засаг даргатай хамтран ажиллах гэрээ байгуулна.”

3/21 дүгээр зүйлийн 21.2.5-21.2.7 дахь заалт:

“21.2.5.хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий болон тухайн жилийн төлөвлөгөөний дагуу газрыг иргэнд өмчлүүлэх асуудлыг шийдвэрлэх;

21.2.6.иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын газар эзэмших, ашиглах эрхийг хүчингүй болгох, дуусгавар болгох, газрын байршил болон хэмжээ, зориулалт өөрчлөх асуудлыг шийдвэрлэх;

21.2.7.энэ хуулийн 21.2.4, 21.2.6-д заасан бүрэн эрхээ дүүргийн Засаг даргад шилжүүлэх.”

4/21 дүгээр зүйлийн 21.5.4 дэх заалт:

“21.5.4.энэ хуулийн 21.2.7-д заасны дагуу эрх шилжүүлэн авсан бол энэ хуулийн 21.2.4, 21.2.6-д заасан шийдвэр гаргах.”

5/23 дугаар зүйлийн 23.7, 23.8 дахь хэсэг:

“23.7.Нийслэлийн газрын алба нь энэ хуулийн 23.3-т зааснаас гадна иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын газар эзэмших эрхийг шилжүүлэх, эзэмших, ашиглах эрхийн хугацааг сунгах хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэнэ.

23.8.Дүүргийн газрын алба нь энэ хуулийн 23.4-т зааснаас гадна иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын газар эзэмших эрхийг шилжүүлэх, эзэмших, ашиглах эрхийн хугацааг сунгах хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэнэ.”

6/24 дүгээр зүйлийн 24.6, 24.7 дахь хэсэг:

“24.6.Энэ хуулийн 24.1-д заасан цогцолбор арга хэмжээг газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим систем /цаашид “цахим систем” гэх/-ээр дамжуулан хэрэгжүүлнэ.

24.7.Энэ хуулийн 18.1.8-д заасан журмаар газрыг төлөвлөх, олгох, кадастр эрхлэх, мониторинг хийх, төлбөр татвар ногдуулах, хаяг олгох зэрэг үйл ажиллагааг цахимаар эрхлэх, системийн удирдлага, тохиргоо, хөгжүүлэлт, аюулгүй байдал, хэрэглэгчийн эрх, үүрэг, хяналт тавих асуудлыг зохицуулна.”

7/29 дүгээр зүйлийн 29.7-29.12 дахь хэсэг:

“29.7.Монгол Улсын иргэн энэ хуулийн 29.1, 29.2, 29.3-т заасан газрыг эзэмших хүсэлтийг засаг захиргааны нэгж болон зориулалтаа сонгож нэг удаа гаргах бөгөөд тухайн иргэний хүсэлт шийдвэрлэгдэх хүртэл өргөдлийн бүртгэлийн мэдээллийн санд хадгалагдана.

29.8.Иргэний үнэ төлбөргүйгээр газар эзэмшихээр цахим системээр гаргасан хүсэлтийг дараах дарааллын дагуу эрэмбэлэн бүртгэнэ:

29.8.1.өмнө нь гэр бүлийн хамтын хэрэгцээнд зориулан хувийн гэр, орон сууцны хашаа барих болон хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, таримал ургамал тарих зориулалтаар үнэ төлбөргүй газар эзэмшиж байгаагүй иргэний хүсэлтийг жагсаалтын эхэнд, цахим системд хүсэлт гаргасан огноогоор;

29.8.2.энэ хуулийн 29.8.1-д зааснаас бусад иргэний хүсэлтийг цахим системд хүсэлт гаргасан огноогоор.

29.9.Иргэний үнэ төлбөргүй газар эзэмших хүсэлтийг өргөдлийн бүртгэлийн мэдээллийн санд бүртгэгдсэн дарааллын дагуу шийдвэрлэнэ.

29.10.Эзэмшил газрын хэмжээ, байршлыг дараах тохиолдолд өөрчилж болно:

29.10.1.улс, орон нутгийн тусгай хэрэгцээнд авах шийдвэр гарсан байршилтай давхацсан;

29.10.2.холбогдох эрх бүхий байгууллагын шийдвэрээр олон улс, улс, орон нутгийн чанартай томоохон дэд бүтэц, бүтээн байгуулалт хийх болон олон улсын зээл тусламж, улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр инженер, нийгмийн дэд бүтэц байгуулахаар төлөвлөж байгаа газартай давхацсан;

29.10.3.хууль, тогтоомжоор тогтоосон хориглолт, хамгаалалт, хязгаарлалтын бүс, зурвас газартай давхацсан;

29.10.4.Засгийн газрын шийдвэрээр геодезийн солбицол, өндөр, тусгагийн тогтолцоо өөрчлөгдсөн;

29.10.5.газар зохион байгуулалтын ерөнхий болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэх;

29.10.6.нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн;

29.10.7.хүн ам, барилгажилтын нягтрал ихтэй бүсэд байрлах газрыг нийтийн эдэлбэрт авах;

29.10.8.нийслэлийн газрын эрхийн маргаан таслах зөвлөлийн шийдвэрээр.

29.11.Энэ хуулийн 29.10-т заасан шийдвэрийг газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө болон эдэлбэр газрын бүсчлэлд нийцүүлэн аймаг, сум, нийслэлийн Засаг дарга гаргана.

29.12.Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх, улс, нийслэлийн хөрөнгө оруулалт болон олон улсын төсөл, хөтөлбөрийн хүрээнд хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгоор газар эзэмших, ашиглах эрх олгоход энэ хуулийн 29.7, 29.8, 29.9-д заасан эрэмбэлэх дараалал хамаарахгүй.”

8/33 дугаар зүйлийн 33.8 дахь хэсэг:

“33.8.Эрх бүхий этгээдийн шийдвэрээр эзэмшүүлсэн, ашиглуулсан газрын хаяг, байршил, хэмжээ, хугацаа болон эзэмшигч, ашиглагчийн талаарх мэдээллийг нийтэд нээлттэй мэдээлнэ.”

9/48¹ дүгээр зүйл:

“48¹ дүгээр зүйл.Сервитут тогтоох

48¹.1.Эрх бүхий байгууллагаас олгосон газар өмчлөх, эзэмших, ашиглах газрын эрхээ хэрэгжүүлэх, хүн амын нийтийн ашиг сонирхлыг хангах зайлшгүй шаардлагатай тохиолдолд бусдын өмчлөх, эзэмших, ашиглах эрхийг хязгаарлаж сервитут тогтоож болно.

48¹.2.Сервитут нь тодорхой нөхцөл, болзол, хугацаатай байх бөгөөд дараах төрөлтэй байна:

48¹.2.1.нийтийн;

48¹.2.2.хувийн.

48¹.3.Сервитутыг дараах зориулалтаар тогтоож болно:

48¹.3.1.дамжин өнгөрөх;

48¹.3.2.хил заагийн болон геодезийн байнгын цэг, тэмдэгт тавих;

48¹.3.3.гамшгийн эрэл болон хор уршгийг арилгах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх;

48¹.3.4.инженерийн барилга байгууламж, шугам сүлжээ байгуулах, ашиглах;

48¹.3.5.хайгуул судалгаа, түүнтэй ижил төстэй бусад үйл ажиллагаа явуулах;

48¹.3.6.усны сан болон ойн сангийн газарт байгалийн дагалт баялаг ашиглах, аялах.

48¹.4.Хүн амын нийтийн ашиг сонирхлыг хангах зайлшгүй шаардлагыг үндэслэн улсын болон орон нутгийн чанартай авто зам, төмөр зам, дүүжин тээвэр, гүүр, гүүрний барилга байгууламж, явган болон дугуйн зам, нийтийн тээврийн үйлчилгээний барилга байгууламж байгуулахад нийтийн сервитут тогтооно.

48¹.5.Энэ хуулийн 48¹.4-т заасны дагуу нийтийн сервитут тогтоосон бол газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхтэй этгээдэд нөхөх олговор олгож



болно. Нөхөх олговрын хэмжээг тооцох, нөхөх олговрыг тогтоох, нөхөх олговрыг дүйцүүлэн тооцох журмыг газрын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.

48^{1.6}.Энэ хуулийн 48^{1.4}-т заасан нийтийн сервитут тогтоох асуудлыг аймаг, нийслэлийн газрын алба, хоёр, түүнээс дээш аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрийг хамарсан нийтийн сервитут тогтоох асуудлыг газрын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, улсын тусгай хэрэгцээний газар нийтийн сервитут тогтоох асуудлыг Засгийн газар шийдвэрлэнэ.

48^{1.7}.Нийтийн сервитут тогтооход эрх нь хязгаарлагдаж байгаа газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагч этгээдэд мэдэгдэж, нийтийн сервитут тогтоох шийдвэрийг энэ хуулийн 48^{1.6}-д заасан байгууллага гарган цахим системд бүртгэнэ.

48^{1.8}.Сервитут тогтоолгуулсан этгээд газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхтэй этгээдийн аливаа үйл ажиллагаанд саад учруулахыг хориглоно.

48^{1.9}.Нийтийн болон хувийн сервитут тогтоох болон дуусгавар болгох шийдвэрийг цахим системд бүртгэнэ.

48^{1.10}.Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхтэй этгээдүүд хоорондоо хувийн сервитут тогтоох гэрээ байгуулан бүртгүүлэх хүсэлтээ сервитут тогтоосон газрын хил заагийг кадастрын зургийн хамт аймаг, нийслэлийн газрын албанд гаргана.

48^{1.11}.Энэ хуулийн 48^{1.10}-д заасан хүсэлтийг аймаг, нийслэлийн газрын алба хүлээн авч, цахим системд бүртгэнэ.

48^{1.12}.Хувийн сервитуттай холбогдсон энэ хуульд зааснаас бусад харилцааг Иргэний хуулиар зохицуулна.”

10/60¹, 60², 60³ дугаар зүйл:

“60¹ дүгээр зүйл.Нийслэлийн нутаг дэвсгэр дэх газартай холбогдон үүссэн маргааныг хянан шийдвэрлэх

60^{1.1}.Газартай холбогдон үүссэн дараах маргааныг доор дурдсан байгууллага, албан тушаалтан шийдвэрлэнэ:

60^{1.1.1}.газартай холбоотой иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд үүссэн маргааныг нийслэл, дүүргийн газрын алба;

60¹.1.2.газрын төлөв байдал, чанар, түүнийг үр ашигтай, зохистой ашиглах, хамгаалах талаар үүссэн маргааныг зохих хяналтын байгууллага, нийслэл, дүүргийн газрын алба;

60¹.1.3.иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын нийслэлийн Засаг даргын шийдвэртэй холбоотой болон газар чөлөөлөх, газрын төлбөртэй холбоотой маргааныг Нийслэлийн газрын эрхийн маргаан таслах зөвлөл;

60¹.1.4.бусдын эзэмшил, ашиглалтад байгаа газрыг хязгаарлагдмал эрхтэйгээр ашиглах болон газартай холбогдон үүссэн эд хөрөнгийн маргааныг арбитрын хэлэлцээртэй бол арбитрын журмаар, бусад тохиолдолд шүүх.

60¹.2.Энэ хуулийн 60¹.1.1, 60¹.1.2-т заасны дагуу гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын гомдлыг нийслэл, дүүргийн газрын алба нь 30 хоногийн дотор шийдвэрлэнэ.

60¹.3.Энэ хуулийн 60¹.2-т заасан хугацаанд нийслэл, дүүргийн газрын алба хариу өгөөгүй, хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлээгүй, нийслэл, дүүргийн газрын албаны шийдвэрийг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь шийдвэрийг гардан авснаас хойш 14 хоногийн дотор энэ хуулийн 60² дугаар зүйлд заасны дагуу Нийслэлийн газрын эрхийн маргаан таслах зөвлөлд гомдол гаргаж болно.

60¹.4.Энэ хуулийн 60¹.1, 60¹.3-т заасан гомдол нь Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байна.

60¹.5.Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн ашиглаж байгаа газартай холбогдон үүссэн маргааныг талуудын хооронд байгуулсан гэрээнд өөрөөр заагаагүй бол энэ зүйлд заасан журмын дагуу шийдвэрлэнэ.

60² дугаар зүйл.Маргаан таслах зөвлөл

60².1.Газар өмчлүүлэх, эзэмших, ашиглах, чөлөөлөхтэй холбоотой энэ хуулийн 60¹.1.3, 60¹.3-т заасны дагуу гаргасан гомдол, Захиргааны ерөнхий хуулийн 94.2-т заасан хүсэлтийг хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий орон тооны бус Нийслэлийн газрын эрхийн маргаан таслах зөвлөл /цаашид “Маргаан таслах зөвлөл” гэх/ ажиллана.

60².2.Маргаан таслах зөвлөлийн ажиллах журам, бүрэлдэхүүнийг Засгийн газар батална. Маргаан таслах зөвлөлийн ажиллах журамд



хурлын ирц, зөвлөлийн гишүүдийн эрх, үүрэг, маргаанд оролцогчдын эрх, үүрэг, тайлбар, нотлох баримтыг хянах, дүгнэлт гаргах, шийдвэрлэх, зөвлөлийн шийдвэрийг мэдээлэх зэрэг асуудлыг тусгасан байна.

60².3.Маргаан таслах зөвлөл нь есөн хүний бүрэлдэхүүнтэй байх ба дарга, нарийн бичгийн дарга, гишүүдээс бүрдэнэ.

60².4.Маргаан таслах зөвлөлийн бүрэлдэхүүнд газрын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, нийслэлийн Засаг даргын Тамгын газар, нийслэлийн газрын албаны төлөөлөл, мэргэжлийн төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулан байгуулна.

60².5.Маргаан таслах зөвлөлийн гишүүн нь газар зохион байгуулагч, газрын кадастр, газрын үнэлгээ, геодезийн инженер, эрх зүйч, эдийн засагч мэргэжилтэй, мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан туршлагатай байна.

60².6.Маргаан таслах зөвлөлийн ажлын албаны үүргийг нийслэлийн газрын алба хэрэгжүүлнэ.

60³ дугаар зүйл.Маргаан таслах зөвлөлд гомдол гаргах, шийдвэрлэх

60³.1.Маргаан таслах зөвлөл нь хууль тогтоомжид нийцүүлэн дүгнэлт гаргана.

60³.2.Маргаан таслах зөвлөл нь маргаанд оролцогч талуудаас нотлох баримт шаардах эрхтэй бөгөөд нотлох баримт ирүүлээгүй бол ирүүлсэн нотлох баримтын хүрээнд гомдлыг хянан дүгнэнэ.

60³.3.Нийслэлийн Засаг дарга, нийслэл, дүүргийн газрын алба энэ хуулийн 60².1-д заасан дүгнэлтийг үндэслэн өмнө гаргасан шийдвэрээ хүчингүй болгох, өөрчлөх шийдвэр гаргаж болно.

60³.4.Гомдол нь Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан шаардлагыг хангаагүй, гомдлын нөхцөл байдлыг цаашид тодруулах шаардлагатай, нэмж тодруулах зүйлийн цар хүрээ нь Маргаан таслах зөвлөлийн магадлан судлах боломжоос хэтэрсэн, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 65.1.3-т заасан шалтгаанаар маргаан таслах зөвлөл нь иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын гомдлыг хянан шийдвэрлэх боломжгүй бол гомдол гаргагчид 14 хоногийн дотор буцаана.

60³.5.Маргаан таслах зөвлөл нь гомдлыг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор шийдвэрлэх бөгөөд нэг удаа 30 хүртэл хоногоор сунгаж болно. Тус дүгнэлтийг маргааны оролцогч талуудад гардуулна.

60³.6.Маргаан таслах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг оролцогч талууд хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд дүгнэлтийг гардан авснаас хойш 30 хоногийн дотор шүүхэд хандах эрхтэй.

60³.7.Маргаан таслах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь маргаан таслах зөвлөлийн хэлэлцсэн асуудал болон гаргасан шийдвэрийн үндэслэлийн тэмдэглэлийг хөтөлж, зөвлөлийн шийдвэрийг гомдол гаргасан хүн, хуулийн этгээдийн нэр, хувийн мэдээллийг таних боломжгүйгээр цахим хуудсаар мэдээлнэ.

60³.8.Маргаан таслах зөвлөл нь маргаан үүссэн шалтгаан, түүний нөхцөлийг арилгуулах, газрын хууль тогтоомж зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор зөвлөмж гаргаж, газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны бүх шатны байгууллагад хүргүүлж болно.”

2 дугаар зүйл.Газрын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсгийн “16.1.16” гэсний дараа “,16.1.17” гэж, 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь заалтын, 23 дугаар зүйлийн 23.2.6 дахь заалтын “16.1.16” гэсний дараа “, 16.1.17, 16.1.18” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Газрын тухай хуулийн дараах зүйл, хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/12 дугаар зүйл:

“12 дугаар зүйл.Хот, тосгон, бусад суурин, нийслэл хотын эдэлбэр газар

12.1.Хот, тосгон, бусад суурины газар болон нийслэл хотын эдэлбэр газарт хот, тосгон, бусад суурины барилга байгууламж, үйлдвэр, уурхайн дэвсгэр газар, инженерийн дэд бүтэц, гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх энгийн болон инженерийн хийц, бүтээц бүхий байгууламжийн газар, нийтийн эдэлбэрийн газар болон цаашид тэлж хөгжих нөөц газар хамаарах бөгөөд эдэлбэр газрын хэмжээ, заагийг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталж, тогтооно.

12.2.Нийтийн эдэлбэрийн газарт хот, тосгон, бусад суурины гудамж, талбай, зам, нийтийн амралт, зугаалга, биеийн тамирын зориулалттай газар, цэцэрлэгт хүрээлэн, оршуулгын газар, хог хаягдлын цэг, цэвэршүүлэх талбай, авто зогсоол, ногоон байгууламж, нийтээр ашиглах барилга байгууламжийн газар, дахин хөгжүүлэх төслийн хүрээнд бий болсон нөөц талбай зэрэг газар хамаарна.

12.3.Хот, тосгон, бусад суурины газар болон нийслэл хотын эдэлбэр газар нь бүсчлэлтэй байна.

12.4.Бүсчлэлд тавигдах шаардлагыг хот, тосгон, бусад суурины эдэлбэр газарт дүрмээр зохицуулах бөгөөд бүсчлэлийн дүрмийг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална.

12.5.Бүсчлэл тогтоох шалгуур үзүүлэлтийг Засгийн газар тогтооно.

12.6.Нийтийн эдэлбэрийн газрын зориулалт, хэмжээ, зааг, ашиглалтын журмыг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал баталж, тогтооно.”

2/21 дүгээр зүйлийн 21.2.3, 21.2.4 дэх заалт:

“21.2.3.хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үе шатны төсөл, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий болон тухайн жилийн төлөвлөгөөний уялдаа холбоог хангах, хэрэгжилтэд хяналт тавих;

21.2.4.хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий болон тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө, бүсчлэлд нийцүүлэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлэх, ашиглуулах, асуудлыг шийдвэрлэх;”

3/21 дүгээр зүйлийн 21.5.3 дахь заалт:

“21.5.3.дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулах;”

4/23 дугаар зүйлийн 23.3.7 дахь заалт:

“23.3.7.эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэрийг үндэслэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай газар эзэмшүүлэх, ашиглуулах асуудлаар гэрээ байгуулж, эрхийн гэрчилгээ олгох үйл ажиллагааг цахим системээр эрхлэн явуулах;”

5/23 дугаар зүйлийн 23.4.2 дахь заалт:

“23.4.2.эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэрийг үндэслэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай газар эзэмшүүлэх, ашиглуулах асуудлаар гэрээ байгуулж, эрхийн гэрчилгээ олгох үйл ажиллагааг цахим системээр эрхлэн явуулах;”

6/24 дүгээр зүйлийн 24.3 дахь хэсэг:

“24.3.Газар зохион байгуулалтын ажлын үнэлгээ, цахим систем болон орон зайн өгөгдлийн мэдээллийн сангаас үзүүлэх үйлчилгээ, лавлагаа, мэдээлэл авах үйлчилгээний хөлсний хэмжээг Засгийн газар тогтооно.”

7/32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсэг:

“32.1.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага газар эзэмших тухай хүсэлтээ цахим систем болон төрийн үйлчилгээний нэгдсэн цахим системээр дамжуулан гаргана.”

8/37 дугаар зүйлийн 37.2 дахь хэсэг:

“37.2.Аймаг, сумын Засаг дарга, нийслэл, дүүргийн газрын алба хугацаа сунгуулах тухай хүсэлтийг хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор эрхийн гэрчилгээ эзэмших нөхцөлийг хангаж ажилласан эсэхийг хянаж, түүнийг хангасан тохиолдолд газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг сунгах шийдвэр гаргана. Уг шийдвэрийг үндэслэн сумын газрын даамал, нийслэл, дүүргийн газрын алба цахим системд бүртгэж, газар эзэмших гэрчилгээ, гэрээг баталгаажуулна.”

9/38 дугаар зүйлийн 38.4 дэх хэсэг:

“38.4.Газар эзэмших эрхийн гэрчилгээг шилжүүлэх тухай хүсэлтийг аймаг, сумын Засаг дарга, нийслэл, дүүргийн газрын алба хүлээн авснаас хойш ажлын 15 өдрийн дотор шийдвэр гаргана. Уг шийдвэрийг үндэслэн сумын газрын даамал, нийслэл, дүүргийн газрын алба тухайн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай газар эзэмших гэрээ байгуулж, улсын бүртгэлд бүртгүүлж, эрхийн гэрчилгээг баталгаажуулна.”

4 дүгээр зүйл.Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.1, 33.1.2 дахь заалтын “тухайн шатны Засаг дарга” гэснийг “аймаг, сум, нийслэлийн Засаг дарга” гэж, 44¹дүгээр зүйлийн 44¹.1 дэх хэсгийн “тухайн шатны Засаг даргад” гэснийг “аймаг, сум, нийслэлийн Засаг даргад” гэж, 40 дүгээр зүйлийн 40.1, 40.4 дэх хэсгийн, 46 дугаар зүйлийн 46.1 дэх хэсгийн “Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга” гэснийг “Аймаг, сум, нийслэлийн Засаг дарга” гэж, 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсгийн “тухайн шатны Засаг даргад” гэснийг “цахим системээр” гэж, 38 дугаар зүйлийн 38.3 дахь хэсгийн “Эрхийн гэрчилгээ шилжүүлэх тухай хүсэлтийг тухайн шатны Засаг дарга” гэснийг “Аймаг, сумын Засаг дарга, нийслэл, дүүргийн газрын алба газар эзэмших эрхийн гэрчилгээ шилжүүлэх тухай хүсэлтийг” гэж, 60 дугаар зүйлийн гарчгийн “Газартай” гэснийг “Аймгийн нутаг дэвсгэр дэх газартай” гэж тус тус өөрчилсүгэй.



5 дугаар зүйл.Нийслэл, дүүргийн 2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан газрыг эзэмших, ашиглахаар гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийг нийслэл, дүүргийн Засаг дарга Газрын тухай хуулийн 33.1, 44.8, 44¹.5-д заасны дагуу шийдвэрлэнэ.

6 дугаар зүйл.Энэ хуулийг Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

7 дугаар зүйл.Энэ хуулийн 1 дүгээр зүйлийн 10 дахь заалт буюу Газрын тухай хуулийн 60¹, 60², 60³ дугаар зүйл, 4 дүгээр зүйлд заасан Газрын тухай хуулийн 60 дугаар зүйлд орсон нэмэлт, өөрчлөлтийг 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

Индриг Голд оа Ноли

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨᠯᠢᠰᠡᠯ, дүүргийн 2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан газрыг эзэмших, ашиглахаар гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийг нийслэл, дүүргийн Засаг дарга Газрын тухай хуулийн 33.1, 44.8, 44¹.5-д заасны дагуу шийдвэрлэнэ.

ᠶ᠋ᠢᠨᠯᠢᠰᠡᠯ, дүүргийн 2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан газрыг эзэмших, ашиглахаар гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийг нийслэл, дүүргийн Засаг дарга Газрын тухай хуулийн 33.1, 44.8, 44¹.5-д заасны дагуу шийдвэрлэнэ.

ᠶ᠋ᠢᠨᠯᠢᠰᠡᠯ, дүүргийн 2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан газрыг эзэмших, ашиглахаар гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийг нийслэл, дүүргийн Засаг дарга Газрын тухай хуулийн 33.1, 44.8, 44¹.5-д заасны дагуу шийдвэрлэнэ.

ᠶ᠋ᠢᠨᠯᠢᠰᠡᠯ, дүүргийн 2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан газрыг эзэмших, ашиглахаар гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийг нийслэл, дүүргийн Засаг дарга Газрын тухай хуулийн 33.1, 44.8, 44¹.5-д заасны дагуу шийдвэрлэнэ.

ᠶ᠋ᠢᠨᠯᠢᠰᠡᠯ, дүүргийн 2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан газрыг эзэмших, ашиглахаар гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийг нийслэл, дүүргийн Засаг дарга Газрын тухай хуулийн 33.1, 44.8, 44¹.5-д заасны дагуу шийдвэрлэнэ.

«...»

ᠶ᠋ᠢᠨᠯᠢᠰᠡᠯ, дүүргийн 2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан газрыг эзэмших, ашиглахаар гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийг нийслэл, дүүргийн Засаг дарга Газрын тухай хуулийн 33.1, 44.8, 44¹.5-д заасны дагуу шийдвэрлэнэ.

ᠶ᠋ᠢᠨᠯᠢᠰᠡᠯ, дүүргийн 2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан газрыг эзэмших, ашиглахаар гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийг нийслэл, дүүргийн Засаг дарга Газрын тухай хуулийн 33.1, 44.8, 44¹.5-д заасны дагуу шийдвэрлэнэ.

ᠶ᠋ᠢᠨᠯᠢᠰᠡᠯ, дүүргийн 2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан газрыг эзэмших, ашиглахаар гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийг нийслэл, дүүргийн Засаг дарга Газрын тухай хуулийн 33.1, 44.8, 44¹.5-д заасны дагуу шийдвэрлэнэ.

ᠶ᠋ᠢᠨᠯᠢᠰᠡᠯ, дүүргийн 2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан газрыг эзэмших, ашиглахаар гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийг нийслэл, дүүргийн Засаг дарга Газрын тухай хуулийн 33.1, 44.8, 44¹.5-д заасны дагуу шийдвэрлэнэ.



д/р. Ө. А. Доржсүрэн :
 «Ө. А. Доржсүрэн...»

д/р. Ө. А. Доржсүрэн : «Ө. А. Доржсүрэн...»
 д/р. Ө. А. Доржсүрэн : «Ө. А. Доржсүрэн...»
 д/р. Ө. А. Доржсүрэн : «Ө. А. Доржсүрэн...»

д/р. Ө. А. Доржсүрэн : «Ө. А. Доржсүрэн...»

д/р. Ө. А. Доржсүрэн : «Ө. А. Доржсүрэн...»
 д/р. Ө. А. Доржсүрэн : «Ө. А. Доржсүрэн...»

д/р. Ө. А. Доржсүрэн : «Ө. А. Доржсүрэн...»

д/р. Ө. А. Доржсүрэн : «Ө. А. Доржсүрэн...»
 д/р. Ө. А. Доржсүрэн : «Ө. А. Доржсүрэн...»

д/р. Ө. А. Доржсүрэн : «Ө. А. Доржсүрэн...»

д/р. Ө. А. Доржсүрэн : «Ө. А. Доржсүрэн...»

д/р. Ө. А. Доржсүрэн : «Ө. А. Доржсүрэн...»

д/р. Ө. А. Доржсүрэн : «Ө. А. Доржсүрэн...»

д/р. Ө. А. Доржсүрэн : «Ө. А. Доржсүрэн...»
 д/р. Ө. А. Доржсүрэн : «Ө. А. Доржсүрэн...»
 д/р. Ө. А. Доржсүрэн : «Ө. А. Доржсүрэн...»

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 12 дугаар сарын 07-ны өдөр

Улаанбаатар хот

БАРИЛГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Барилгын тухай хуулийн 33 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 33.1.25 дахь заалт нэмсүгэй:

“33.1.25.барилга байгууламж ашиглалтад оруулах комиссын ажиллах зардлын жишиг хэмжээг барилга байгууламжийн төвөгшил, хэмжээг харгалзан тогтоох.”

2 дугаар зүйл.Барилгын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.25 дахь заалтын дугаарыг “33.1.26” гэж, 37 дугаар зүйлийн 37.1.20 дахь заалтын “ашиглалтад оруулах” гэснийг “ашиглалтад оруулах болон ашиглалтад оруулах комиссын ажиллах” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

Mongol State Court

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠰᠠᠭᠤᠨ ᠬᠤᠷᠭᠠ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ
ᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠰᠠᠭᠤᠨ ᠬᠤᠷᠭᠠ

ᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠰᠠᠭᠤᠨ ᠬᠤᠷᠭᠠ
ᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠰᠠᠭᠤᠨ ᠬᠤᠷᠭᠠ

ᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠰᠠᠭᠤᠨ ᠬᠤᠷᠭᠠ
ᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠰᠠᠭᠤᠨ ᠬᠤᠷᠭᠠ

ᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠰᠠᠭᠤᠨ ᠬᠤᠷᠭᠠ
ᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠰᠠᠭᠤᠨ ᠬᠤᠷᠭᠠ

ᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠰᠠᠭᠤᠨ ᠬᠤᠷᠭᠠ
ᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠰᠠᠭᠤᠨ ᠬᠤᠷᠭᠠ

ᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠰᠠᠭᠤᠨ ᠬᠤᠷᠭᠠ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 12 дугаар
сарын 07-ны өдөр

Улаанбаатар
хот

ЭРҮҮГИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эрүүгийн хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:

1/1.10 дугаар зүйлийн 10 дахь хэсэг:

“10.Энэ хуулийн 12.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 12.3 дугаар зүйлийн 2.1, 3.2 дахь заалт, 13.1 дүгээр зүйлийн 2.1 дэх заалтад заасан гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа тоолохыг зогсоож, хохирогчийг арван найман насанд хүрсний дараа тоолж эхэлнэ.”

2/6.12 дугаар зүйлийн 6 дахь хэсэг:

“6.Энэ хуулийн 10.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 12.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, 12.3 дугаар зүйлийн 4.1 дэх заалт, 13.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэг, 22.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 22.4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 22.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан гэмт хэрэг үйлдсэн ялтныг хорих ялаас хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоохгүй.

Тайлбар: -Гэмт хэрэг үйлдэх үедээ арван найман насанд хүрээгүй хүнд энэ зүйлийн 6 дахь хэсэг хамаарахгүй.”

3/6.14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг:

“3.Энэ хуулийн 10.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 12.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, 12.3 дугаар зүйлийн 4.1 дэх заалт, 13.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан гэмт хэрэгт өршөөл үзүүлэхгүй.

Тайлбар: -Гэмт хэрэг үйлдэх үедээ арван найман насанд хүрээгүй хүнд энэ зүйлийн 3 дахь хэсэг хамаарахгүй.”

4/10.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг:

“3.Бага насны хүүхдийг алсан бол арван хоёр жилээс хорин таван жил хүртэл хугацаагаар, эсхүл бүх насаар нь хорих ял шийтгэнэ.”

2 дугаар зүйл. Эрүүгийн хуулийн 5.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “тохиолдолд” гэсний дараа “тээврийн хэрэгслийг жолоодох эрхийг нэг жилээс арван хоёр жил хүртэл, эсхүл” гэж, 12.2 дугаар зүйлийн 1 дэх



хэсгийн “далимдуулж” гэсний дараа “бэлгийн шинжтэй тодорхой үйлдэл хийсэн, эсхүл хохирогчоор хийлгэж” гэж, мөн зүйлийн тайлбарт “-Бага насны хүүхдийн эсрэг энэ гэмт хэргийг үйлдсэнд тооцоход энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан аргаар үйлдсэн байхыг шаардахгүй.” гэсэн 2 дахь өгүүлбэр тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Эрүүгийн хуулийн дараах зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/21.9 дүгээр зүйл:

“21.9 дүгээр зүйл. Мөрдөн шалгах ажиллагааны нууцыг задруулах

1. Мөрдөн шалгах ажиллагааны талаарх баримт, мэдээллийг олж мэдсэн хүн мөрдөн шалгах ажиллагааны талаарх баримт, мэдээллийг задруулсан бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.

2. Мөрдөн шалгах ажиллагааны талаар албаны үүргийн дагуу олж мэдсэн алба хаагч, ажилтан прокурорын зөвшөөрөлгүйгээр мөрдөн шалгах ажиллагааны талаарх баримт, мэдээллийг задруулсан бол нийтийн албанд ажиллах эрхийг нэг жилээс гурван жил хүртэл хугацаагаар хасаж хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3. Шүүгч, прокурор, хууль сахиулагч, өмгөөлөгч, мөрдөн шалгах ажиллагааны нууцыг албаны үүргийн дагуу олж мэдсэн алба хаагч, ажилтан мөрдөн шалгах ажиллагааны нууцалсан баримт, мэдээллийг зориуд задруулж, нууцалсан гэрчийг илчилж хэрэг шалган шийдвэрлэх ажиллагаанд саад учруулсан бол нийтийн албанд ажиллах эрхийг гурван жилээс таван жил хүртэл хугацаагаар хасаж нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.”

2/27.10 дугаар зүйл:

“27.10 дугаар зүйл. Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих



1.Тээврийн хэрэгслийн жолооч хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөний улмаас хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол учруулсан бол тээврийн хэрэгслийг жолоодох эрхийг нэг жилээс гурван жил хүртэл хугацаагаар хасаж хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.

2.Энэ гэмт хэргийг:

2.1.согтуурсан, мансуурсан үедээ;

2.2.тээврийн хэрэгслийг жолоодох эрхгүй хүн;

2.3.хүний эрүүл мэндэд хүнд хохирол учруулж үйлдсэн бол тээврийн хэрэгслийг жолоодох эрхийг гурван жилээс дээш таван жил хүртэл хугацаагаар хасаж нэг жилээс гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3.Энэ гэмт хэргийн улмаас хүний амь нас хохирсон бол тээврийн хэрэгслийг жолоодох эрхийг таван жилээс дээш найман жил хүртэл хугацаагаар хасаж нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

4.Энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан гэмт хэргийг:

4.1.согтуурсан, мансуурсан үедээ үйлдсэн;

4.2.энэ гэмт хэргийн улмаас хоёр, түүнээс олон хүний амь нас хохирсон бол тээврийн хэрэгслийг жолоодох эрхийг найман жилээс дээш арван хоёр жил хүртэл хугацаагаар хасаж хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

5.Тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулсан хүн согтуурсан, мансуурсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон, эсхүл согтуурсан, мансуурсан эсэхийг зохих журмын дагуу шалгуулахаас зайлсхийсэн бол тээврийн хэрэгслийг жолоодох эрхийг нэг жилээс гурван жил хүртэл хугацаагаар хасаж хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.



Тайлбар: -Энэ зүйлд заасан “согтуурсан” гэж шалгаж, тогтоох ажиллагааны үр дүнд шалгуулагчийн амьсгал дахь спиртийн агууламж 0.20, түүнээс дээш промилль (%), эсхүл цусан дахь спиртийн агууламж 0.5, түүнээс дээш промилль (%) илэрснийг ойлгоно.

-“Тээврийн хэрэгслийн жолооч” гэж тээврийн хэрэгсэл жолоодож яваа тээврийн хэрэгслийг жолоодох эрхтэй, эсхүл эрхгүй, эсхүл жолоодох эрх нь дуусгавар болсон хүнийг ойлгоно.

-“Тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулсан хүн” гэж согтуурсан, мансуурсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон, эсхүл согтуурсан, мансуурсан эсэхийг зохих журмын дагуу шалгуулахаас зайлсхийсэн үйлдлийн улмаас тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулсан хүнийг ойлгоно.

-“Тээврийн хэрэгсэл” гэж механикжсан тээврийн хэрэгслийг ойлгоно.”

4 дүгээр зүйл. Эрүүгийн хуулийн 5.6 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн, 12.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн “хорин” гэснийг “хорин таван” гэж, 5.6 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн “хорин таван” гэснийг “гучин” гэж, 12.3 дугаар зүйлийн 4.1 дэх заалтын “хүүхдийг албадан оруулж” гэснийг “хүүхдийн эсрэг” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл. Эрүүгийн хуулийн 10.1 дүгээр зүйлийн 2.7 дахь заалтын “бага насны хүүхэд,” гэснийг хассугай.

6 дугаар зүйл. Энэ хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

Хүчингээтнэсэнэйгэеэ

2020 оны 11 сарын 10 - 11 сарын 11

Хүчингээтнэсэнэйгэеэ
Хүчингээтнэсэнэйгэеэ

1. Хүчингээтнэсэнэйгэеэ... Хүчингээтнэсэнэйгэеэ

2020 оны 11 сарын 10

«Хүчингээтнэсэнэйгэеэ... Хүчингээтнэсэнэйгэеэ»
Хүчингээтнэсэнэйгэеэ... Хүчингээтнэсэнэйгэеэ

2020 оны 11 сарын 10

«Хүчингээтнэсэнэйгэеэ... Хүчингээтнэсэнэйгэеэ»
Хүчингээтнэсэнэйгэеэ... Хүчингээтнэсэнэйгэеэ

Хүчингээтнэсэнэйгэеэ... Хүчингээтнэсэнэйгэеэ
Хүчингээтнэсэнэйгэеэ... Хүчингээтнэсэнэйгэеэ

2020 оны 11 сарын 10

Хүчингээтнэсэнэйгэеэ... Хүчингээтнэсэнэйгэеэ
Хүчингээтнэсэнэйгэеэ... Хүчингээтнэсэнэйгэеэ





МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 12 дугаар
сарын 07-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Зөрчлийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

1/3.3 дугаар зүйлийн 1.2 дахь заалт:

“1.2.нийтэд тустай ажил хийлгэх,”

2/3.4 дүгээр зүйлийн 8, 9 дэх хэсэг:

“8.Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний акт зөрчсөнтэй холбогдуулан эрх бүхий этгээдээс оногдуулсан торгох шийтгэлийг хуульд заасан хугацаанд биелүүлээгүй бол тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэх авах, сунгах, ангилал нэмэх, өөрчлөх, нөхөн авах, тээврийн хэрэгслийн эзэмшлийн шилжилт хөдөлгөөн хийх эрхийг хязгаарлана. Хүн, хуулийн этгээд эрх бүхий этгээдээс оногдуулсан торгох шийтгэлийг энэ хуулийн 3.5 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан хугацаанд биелүүлээгүй бол цагдаагийн алба хаагч тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг торгох шийтгэлийг биелүүлж дуусах хүртэл хугацаанд хязгаарлана. Энэ тохиолдолд тээврийн хэрэгслийг хуульд заасан журмын дагуу тусгай талбайд хүргэх, эсхүл холбогдох хууль тогтоомжид заасан бусад аргаар хөдөлгөөнийг нь хязгаарлана.

9.Энэ зүйлийн 8 дахь хэсэгт заасан эрхийг хязгаарлах, эрх бүхий албан тушаалтан, шүүх болон эрх бүхий байгууллага хооронд мэдээлэл солилцох журмыг Улсын ерөнхий прокурор, хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.”

3/3.5, 3.6 дугаар зүйл:

“3.5 дугаар зүйл.Торгох шийтгэлийн хэмжээг хөнгөрүүлэх, нэмэгдүүлэх үндэслэл

1.Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд нь эрх бүхий албан тушаалтан, шүүхээс оногдуулсан торгох шийтгэлийг хуулиар тогтоосон хугацаанд биелүүлэх бол шийтгэлийн хэмжээг 50 хувиар хөнгөрүүлнэ.



2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан шийтгэлийн хэмжээг хөнгөрүүлсэн нь зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд албадлагын арга хэмжээ авахгүй байх үндэслэл болохгүй.

3.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу шийтгэлийн хэмжээг хөнгөрүүлэх үндэслэл энэ хуулийн 5.2, 5.3, 5.4, 5.5, 5.6, 5.7, 5.8, 5.10, 5.11, 5.12, 5.13, 5.14, 5.15, 5.18, 5.20, 6.4, 6.5, 6.6, 6.7, 6.8, 6.10, 6.11, 6.12, 6.14, 6.15, 6.17, 6.18, 6.20, 6.22, 6.23, 6.26, 6.27 дугаар зүйл, Долдугаар бүлэг, 8.1, 8.6, 8.7, 8.8, 8.9, 9.7, 10.3, 10.7, 10.15, 10.25 дугаар зүйл, Арван нэгдүгээр бүлэг, 12.1, 12.2, 12.3, 12.4, 12.5, 12.6, 12.8, 12.9, 12.10, 12.11, 13.1, 13.2, 13.4, 13.5, 13.6, 14.1, 14.2, 14.3, 14.4, 14.5, 14.6, 14.8, 14.9, 14.10, 14.11, 14.12, 14.13 дугаар зүйл, Арван тав, Арван зургадугаар бүлэг, 17.1 дүгээр зүйлд заасан зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд хамаарахгүй.

4.Эрх бүхий албан тушаалтнаас оногдуулсан торгох шийтгэлийг энэ хуульд заасан хугацаанд биелүүлээгүй бол шийтгэлийн хэмжээг 50 хүртэл хувиар нэмэгдүүлнэ.

5.Энэ зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу торгох шийтгэлийг нэмэгдүүлж тооцох хугацаа, аргачлалыг Улсын ерөнхий прокурор, хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

6.Шүүх, эрх бүхий албан тушаалтан торгох шийтгэлийг нэг жил хүртэл хугацаанд хэсэгчлэн төлүүлэхээр шийдвэрлэсэн бол энэ зүйлийн 1, 4 дэх хэсэг хамаарахгүй.

3.6.Нийтэд тустай ажил хийлгэх шийтгэл

1.Зөрчил үйлдсэн хүн энэ хуулийн 3.5 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу торгох шийтгэлийг биелүүлээгүй бол шүүхээс тогтоосон нийтийн ашиг сонирхолд тустай ажлыг цалин хөлс олгохгүйгээр хийлгэхийг нийтэд тустай ажил хийлгэх шийтгэл гэнэ.

2.Шүүх нийтэд тустай ажил хийлгэх шийтгэлийг өдөрт наймаас дээшгүй цагаар, нийт хоёр зуун дөчөөс долоон зуун хорин цагаар тогтооно.

3.Энэ хуулийн 3.5 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан торгох шийтгэлийг биелүүлээгүй бол торгох шийтгэлийн арван таван нэгжийг найман цагийн нийтэд тустай ажил хийлгэх шийтгэлээр тооцож солино.

4.Нийтэд тустай ажил хийлгэх шийтгэлийг хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хүнд, биеийн эрүүл мэндэд шууд нөлөөлөхүйц нийтэд тустай ажил хийлгэх шийтгэлийг жирэмсэн эмэгтэй, тавин таваас дээш насны эмэгтэй, жараас дээш насны эрэгтэй хүнд оногдуулахгүй.”

2 дугаар зүйл.Зөрчлийн тухай хуулийн 3.3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “үндсэн,” гэсний дараа “нийтэд тустай ажил хийлгэх,” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл.Зөрчлийн тухай хуулийн 14.7 дугаар зүйлийн 5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“5.Жолооч:

5.1.согтуурсан, мансуурсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон;

5.2.тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй, эсхүл жолоодох эрх нь дуусгавар болсон хүн согтуурсан, мансуурсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон;

5.3.согтуурсан, мансуурсан эсэхийг зохих журмын дагуу шалгуулахаас зайлсхийсэн бол тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг нэг жилийн хугацаагаар хасаж дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна.”

4 дүгээр зүйл.Зөрчлийн тухай хуулийн 3.3 дугаар зүйлийн 1.2, 1.3 дахь заалтын дугаарыг “1.3, 1.4” гэж, 3.5, 3.6, 3.7, 3.8 дугаар зүйлийн дугаарыг “3.7, 3.8, 3.9, 3.10” гэж, 14.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “хоёр зуун” гэснийг “дөрвөн зуун” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл.Зөрчлийн тухай хуулийн 14.7 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

6 дугаар зүйл.Энэ хуулийг 2023 оны 12 дугаар сарын 07-ны өдөр баталсан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 12 дугаар
сарын 07-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, заалт нэмсүгэй:

1/7.1 дүгээр зүйлийн 1.7 дахь заалт:

“1.7.Зөрчлийн тухай хуулийн 3.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу торгох шийтгэлийг хөнгөрүүлэх, эсхүл нэмэгдүүлэх эсэх.”

2/7.6 дугаар зүйл:

“7.6 дугаар зүйл.Торгох шийтгэлийг хөнгөрүүлэх, нэмэгдүүлэх

1.Шийтгэлийн хуудсанд заасан торгох шийтгэлийг хэсэгчлэн төлүүлэх шийдвэр нь торгох шийтгэлийг хөнгөрүүлсэн нөхцөлд хамаарахгүй.

2.Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд торгох шийтгэлийг энэ хуулийн 7.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан хугацаанд багтаан бүрэн төлнө.

3.Зөрчил үйлдсэн хүн Зөрчлийн тухай хуулийн 3.5 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан торгох шийтгэлийг биелүүлээгүй бол эрх бүхий албан тушаалтан нийтэд тустай ажил хийлгэх шийтгэлээр солих саналаа оршин суугаа /оршин байгаа/ газар, эсхүл тухайн зөрчил гаргасан харьяаллын шүүхэд хүргүүлнэ.”

2 дугаар зүйл.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.6 дугаар зүйлийн 8 дахь хэсэг, 6.12 дугаар зүйлийн 12 дахь хэсэг, 7.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 7.5 дугаар зүйлийн 8 дахь хэсэг, 8.1 дүгээр зүйлийн 14 дэх хэсгийн “7.6” гэснийг “7.7” гэж, 7.6 дугаар зүйлийн дугаарыг “7.7” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг 2023 оны 12 дугаар сарын 07-ны өдөр баталсан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР



Илдэглэл - 2

Мөнхсайхангийн тусламж

2024 оны 2 сар 15 - 20 оны хоногийн хоногийн тусламж

Мөнхсайхангийн тусламж
Мөнхсайхангийн тусламж
Мөнхсайхангийн тусламж

1. Мөнхсайхангийн тусламж... Мөнхсайхангийн тусламж... Мөнхсайхангийн тусламж...
2. Мөнхсайхангийн тусламж... Мөнхсайхангийн тусламж... Мөнхсайхангийн тусламж...

3. Мөнхсайхангийн тусламж... Мөнхсайхангийн тусламж... Мөнхсайхангийн тусламж...
4. Мөнхсайхангийн тусламж... Мөнхсайхангийн тусламж... Мөнхсайхангийн тусламж...

5. Мөнхсайхангийн тусламж... Мөнхсайхангийн тусламж... Мөнхсайхангийн тусламж...
6. Мөнхсайхангийн тусламж... Мөнхсайхангийн тусламж... Мөнхсайхангийн тусламж...

7. Мөнхсайхангийн тусламж... Мөнхсайхангийн тусламж... Мөнхсайхангийн тусламж...
8. Мөнхсайхангийн тусламж... Мөнхсайхангийн тусламж... Мөнхсайхангийн тусламж...

9. Мөнхсайхангийн тусламж... Мөнхсайхангийн тусламж... Мөнхсайхангийн тусламж...
10. Мөнхсайхангийн тусламж... Мөнхсайхангийн тусламж... Мөнхсайхангийн тусламж...

11. Мөнхсайхангийн тусламж... Мөнхсайхангийн тусламж... Мөнхсайхангийн тусламж...
12. Мөнхсайхангийн тусламж... Мөнхсайхангийн тусламж... Мөнхсайхангийн тусламж...

Мөнхсайхангийн тусламж
Мөнхсайхангийн тусламж
Мөнхсайхангийн тусламж

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 12 дугаар
сарын 07-ны өдөр

Улаанбаатар
хот

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд доор дурдсан агуулгатай 151¹ дүгээр зүйл нэмсүгэй:

“151¹ дүгээр зүйл. Нийтэд тустай ажил хийлгэх шийтгэлийг гүйцэтгэх

151^{1.1}. Нийтэд тустай ажил хийлгэх шийтгэлийг гүйцэтгэх ажиллагааг эхлүүлэх, зохион байгуулах ажиллагааг гүйцэтгэхэд энэ хуулийн 162, 163, 164 дүгээр зүйлд заасан журмыг баримтална.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2023 оны 12 дугаар сарын 07-ны өдөр баталсан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

Индрига Фола на Нави

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ

«ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ»

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 12 дугаар
сарын 07-ны өдөр

Улаанбаатар
хот

ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:

1/32 дугаар зүйлийн 32.10, 32.11 дэх хэсэг:

“32.10.Цагдаагийн байгууллагаас ирүүлсэн бага насны хүүхэд сураггүй алга болсон, олдсон тухай хойшлуулшгүй мэдээллийг харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгч этгээд үнэ төлбөргүй, нийтэд мэдээлнэ.

32.11.Энэ хуулийн 32.10-т заасан ажиллагааг зохицуулах журмыг хууль зүйн болон цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.”

2/41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсэг:

“41.2.Эрүүгийн хуулийн 10.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 12.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, 12.3 дугаар зүйлийн 4.1 дэх заалт, 13.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан гэмт хэрэг үйлдэж, хорих ял эдэлж дууссан, Эрүүгийн хуулийн 6.13 дугаар зүйлд заасны дагуу хорих ялаас өвчний учир чөлөөлөгдсөн болон Эрүүгийн хуулийн 6.14 дүгээр зүйлд заасны дагуу уучлалд хамрагдсан хүний зорчих хөдөлгөөнд тоног төхөөрөмж ашиглан хяналт тогтооно.”

3/41 дүгээр зүйлийн 41.7 дахь хэсэг:

“41.7.Энэ хуулийн 41.2-т заасан зорчих хөдөлгөөнд хяналт тавих тоног төхөөрөмжийн жагсаалт, тэдгээрийг ашиглах журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”

4/42 дугаар зүйлийн 42.2 дахь хэсэг:

“42.2.Энэ хуулийн 41.2-т заасан хүнд шүүхээс оногдуулсан хорих ялын хоёрны нэгээс доошгүй хугацаагаар нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын даргын шийдвэрээр хяналт тогтооно.”

5/44 дүгээр зүйлийн 44.2 дахь хэсэг:

“44.2.Энэ хуулийн 41.2-т заасан хяналтад байгаа этгээдийн бүртгэлийг цагдаагийн байгууллага хөтөлнө.”

2 дугаар зүйл.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 32 дугаар зүйлийн гарчгийн “урьдчилан сэргийлэх талаар” гэсний дараа “харилцаа холбоо,” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2, 41.3, 41.4, 41.5 дахь хэсгийн дугаарыг “41.3, 41.4, 41.5, 41.6” гэж, мөн зүйлийн 41.2, 41.4 дэх хэсгийн “41.1-д” гэснийг “41.1, 41.2-т” гэж, 42 дугаар зүйлийн 42.2, 42.3, 42.4, 42.5, 42.6, 42.7 дахь хэсгийн дугаарыг “42.3, 42.4, 42.5, 42.6, 42.7, 42.8” гэж, мөн зүйлийн 42.6 дахь хэсгийн “42.2, 42.3, 42.4-т” гэснийг “42.3, 42.4, 42.5-д” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Энэ хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсгийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөх бөгөөд шаардагдах зардлыг Монгол Улсын Засгийн газар холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэнэ.

5 дугаар зүйл.Энэ хуулийг 2023 оны 12 дугаар сарын 07-ны өдөр баталсан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

Индрига Фола на Холл
Индрига Фола на Холл
Индрига Фола на Холл

Индрига Фола на Холл...
Индрига Фола на Холл...
Индрига Фола на Холл...

Индрига Фола на Холл

Индрига Фола на Холл...
Индрига Фола на Холл...
Индрига Фола на Холл...

Индрига Фола на Холл...
Индрига Фола на Холл...
Индрига Фола на Холл...

Индрига Фола на Холл

Индрига Фола на Холл...
Индрига Фола на Холл...
Индрига Фола на Холл...

Индрига Фола на Холл

Индрига Фола на Холл...
Индрига Фола на Холл...
Индрига Фола на Холл...



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 11 дүгээр
сарын 30-ны өдөр

Дугаар 105

Улаанбаатар
хот

Хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.10 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 10 дугаар сарын 31-ний өдөр Улсын Их Хуралд Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Авто замын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг буцаах нь зүйтэй гэсэн Байнгын хорооны санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул хууль санаачлагчид буцаасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 12 дугаар
сарын 07-ны өдөр

Дугаар 107

Улаанбаатар
хот

Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хууль баталсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай:

1/Монгол Улсын Их Хурлын 1995 оны 26 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 3-т заасан Богдхан уулын дархан цаазат газрын хилийн заагийн хэмжээг бууруулахгүйгээр хилийн цэст өөрчлөлт оруулах асуудлыг судлан шийдвэрлүүлэх, уг нутаг дэвсгэрт үүссэн суурьшлын бүсийг нийслэл Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд нийцүүлэн иргэдийн хотын нийтийн аж ахуйн үйлчилгээ авах эрхийг хангах арга хэмжээ авах;

2/Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулиар нийслэлийн хэмжээнд нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн газар албадан чөлөөлөхтэй холбогдсон харилцааг зохицуулсан тул цаашид улсын хэмжээнд нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн газар албадан чөлөөлөхтэй холбогдсон эрх зүйн зохицуулалтыг бий болгох зорилгоор хуулийн төсөл боловсруулж, Монгол Улсын Их Хуралд яаралтай өргөн мэдүүлэх;

3/Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.6 дахь хэсгийн хэрэгжилтийг хангах хүрээнд нийслэл Улаанбаатар хотын орон сууцны байшингийн цахилгаан шатны болон дулааны техникийн шинэчлэл /фасад, дээвэр, босоо шугам, хаяавч, узель/-д шаардагдах хөрөнгийг улсын болон орон нутгийн төсөвт тусгаж шийдвэрлэх;

4/Нийслэл Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төслийг 2023 оны 12 дугаар сард багтаан боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;



5/Хот байгуулалтын тухай хуулийн 9.4-т заасны дагуу аймаг, нийслэлийн ерөнхий архитекторын эрх, үүргийг мэргэжлийн байгууллага, хуулийн этгээд хэрэгжүүлэх тохиолдолд ерөнхий архитекторын албан тушаалыг төрийн захиргааны албан тушаалд хамааруулсан холбогдох шийдвэрт өөрчлөлт оруулах;

6/Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулийн 6.3-т заасан журамд Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийг дагаж мөрдөхөөс өмнө Хот байгуулалтын тухай хуулийн 12.6.3, 12.8-д заасан шаардлагыг хангаагүй барилга байгууламжийг хамруулах асуудлыг тусгах;

7/Зөрчлийн тухай хуулийн 6.30 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан торгох шийтгэл цахим платформд бүртгэлтэй зорчигч тээвэрлэдэг иргэнд хамаарахгүй байхаар зохицуулах.

2.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо /Ж.Батжаргал/, Төсвийн байнгын хороо /Г.Тэмүүлэн/, Төрийн байгуулалтын байнгын хороо /Н.Энхболд/, Эдийн засгийн байнгын хороо /Ц.Цэрэнпунцаг/-нд тус тус даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР



Модуль Folo_02 Yakh Horid on Doodlegra

Ажлын үндэсний үнэмлэх

2024 он

Хүндэтгэсэн ажлын үнэмлэх / 2024 он / 02 / 02

Ажлын үндэсний үнэмлэх / 2024 он / 02 / 02

Ажлын үндэсний үнэмлэх / 2024 он / 02 / 02

Ажлын үндэсний үнэмлэх / 2024 он / 02 / 02

Ажлын үндэсний үнэмлэх / 2024 он / 02 / 02

Ажлын үндэсний үнэмлэх / 2024 он / 02 / 02

Ажлын үндэсний үнэмлэх / 2024 он / 02 / 02



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 12 дугаар
сарын 07-ны өдөр

Дугаар 108

Улаанбаатар
хот

Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай:

1/татварын хөнгөлөлт, чөлөөлөлт болон татварыг хэсэгчлэн төлөх, хугацааг сунгах асуудлыг бусад хууль тогтоомжтой нийцүүлэх асуудлыг судалж, холбогдох төслийг боловсруулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

2/““Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай” Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолд заасан “Нүүрстөрөгч багатай, бүтээмжтэй, хүртээмжтэй ногоон хөгжил” зорилтын хүрээнд дулааны болон цахилгааны эрчим хүчний үйлдвэрлэлд ашиглаж буй түүхий эдийн стандартыг дээшлүүлэх замаар уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

2.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо /Г.Тэмүүлэн/, Эдийн засгийн байнгын хороо /Ц.Цэрэнпунцаг/-нд тус тус даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

Mongol Folk_02 Yakh Horla and Doolagla

МОНГОЛ УЛСЫН
ХАМГААГАХ АЖ АХуй
ЯРИХ АНГАМ

905

2024 оны 2 сар 15

МОНГОЛ УЛСЫН
ХАМГААГАХ АЖ АХуй
ЯРИХ АНГАМ

МОНГОЛ УЛСЫН ХАМГААГАХ АЖ АХуй ЯРИХ АНГАМ
2024 оны 2 сар 15

МОНГОЛ УЛСЫН ХАМГААГАХ АЖ АХуй ЯРИХ АНГАМ
2024 оны 2 сар 15

МОНГОЛ УЛСЫН ХАМГААГАХ АЖ АХуй ЯРИХ АНГАМ
2024 оны 2 сар 15

МОНГОЛ УЛСЫН ХАМГААГАХ АЖ АХуй ЯРИХ АНГАМ
2024 оны 2 сар 15

МОНГОЛ УЛСЫН ХАМГААГАХ АЖ АХуй ЯРИХ АНГАМ
2024 оны 2 сар 15

МОНГОЛ УЛСЫН
ХАМГААГАХ АЖ АХуй
ЯРИХ АНГАМ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 12 дугаар
сарын 22-ны өдөр

Дугаар 115

Улаанбаатар
хот

Хянан шалгах түр хорооны ажиллах хугацааг сунгах тухай

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.8 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 93 дугаар зүйлийн 93.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 60 дугаар тогтоолоор байгуулсан Эмийн үнийн өсөлтийн шалтгаан, нөхцөлийг хянан шалгах үүрэг бүхий Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооны ажиллах хугацааг 2023 оны 12 дугаар сарын 30-ны өдрөөс зургаан сараар сунгасугай.

2. Энэ тогтоолыг 2023 оны 12 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

Монгол Фолькlor ба Хөдөлгөөний Догдлол

᠑᠙᠙᠔ он ᠑᠑ сар ᠒᠑ - ᠒᠑ - сар ᠒᠑ өдөр

᠑᠑᠙᠔ он

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛААНБААТАР
УЛСЫН ЭРХ ЗЭВХЭЙН
ТӨСӨВ

᠑᠙᠙᠔ он ᠑᠑ сар ᠒᠑ - ᠒᠑ - сар ᠒᠑ өдөр
᠒᠑ сар ᠒᠑ өдөр

᠑᠙᠙᠔ он ᠑᠑ сар ᠒᠑ - ᠒᠑ - сар ᠒᠑ өдөр
᠒᠑ сар ᠒᠑ өдөр

᠑᠙᠙᠔ он ᠑᠑ сар ᠒᠑ - ᠒᠑ - сар ᠒᠑ өдөр

᠒᠑ сар ᠒᠑ өдөр

᠒᠑ сар ᠒᠑ өдөр



Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medeel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 11

Индекс: 200003